



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР



ХҮНИЙ ЭРХ, ЖЕНДЭРИЙН АСУУДЛААРХ ПАРЛАМЕНТЫН ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭ

Үйл ажиллагааны тайлан болон санал, зөвлөмж

2023 оны 11 дүгээр сарын 22, 23-ны өдрүүд
Улаанбаатар хот

АГУУЛГА

ОРШИЛ	2
НЭГ. ҮНЭЛГЭЭНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА	4
1.1. Үнэлгээний бэлтгэл ажил	4
1.2. Үнэлгээний ерөнхий зохион байгуулалт.....	5
1.3. Үнэлгээний урьдчилсан үр дүнг танилцуулсан байдал.....	6
ХОЁР. ҮНЭЛГЭЭНИЙ САНАЛ, ЗӨВЛӨМЖ	7
2.1. Хүний эрхийн асуудлаарх санал, зөвлөмж.....	7
2.2. Жендэрийн асуудлаарх санал, зөвлөмж	11

ОРШИЛ

Монгол Улсын Их Хурал, Олон Улсын Парламентын Холбоо (ОУПХ) 2022 оны 8 дугаар сарын 10-ны өдөр “Хамтран ажиллах санамж бичиг” байгуулж, хүний эрхийг дээдэлсэн, жендэрийн мэдрэмжтэй парламентыг бэхжүүлэх чиглэлээр хамтран ажиллахаар тохиролцсон билээ. Энэ хүрээнд УИХ болон түүний Тамгын газрын үйл ажиллагаанд хүний эрхийн болон жендэрийн мэдрэмжтэй байдлын өөрийн үнэлгээг хийхээр тусгасан болно.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2019-2024 оны стратеги төлөвлөгөөний 3 дугаар зорилтод “Жендэрийн тэгш байдлыг хангаж, эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дэмжих, Улсын Их Хурал дахь эмэгтэй гишүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх механизмыг бүрдүүлж, жендэрийн мэдрэмжтэй парламентыг төлөвшүүлэх;” гэж, “Хуулийн төслүүд хүний эрхийг хангасан эсэхэд нөлөөллийн үнэлгээ хийж, Хүний эрхийн олон улсын конвенц болон НҮБ-аас хүний эрхийн талаар гаргасан зөвлөмжүүдтэй нийцүүлж баталдаг болох;” гэж тус тус заасан.

Хүний эрхийн өөрийн үнэлгээний аргачлал нь хүний эрх болон Тогтвортой хөгжлийн зорилгууд (ТХЗ) хоорондын уялдаа холбоонд тулгуурлан олон улсын хүний эрхийн механизмаас өгсөн зөвлөмжийг харгалзан үзэхэд нь парламентад дэмжлэг үзүүлэх зорилготой. Харин парламентын жендэрийн мэдрэмжтэй байдлын өөрийн үнэлгээний аргачлал нь бүтэц, үйл ажиллагаа, ажиллах зарчмын хувьд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хэрэгцээ, сонирхолд нийцсэн буюу жендэрийн мэдрэмжтэй парламентыг төлөвшүүлэх зорилгоор өөрийн улсын онцлог нөхцөл байдалд тохирсон тодорхой зорилтуудыг дэвшүүлж, шинэчлэлийн ерөнхий зураглал боловсруулах боломжийг олгодог байна.¹

ОУПХ-ны удирдамжид тусгаснаар парламентын өөрийн үнэлгээг дараах зорилгоор зохион байгуулдаг. Үүнд:

- Олон улсын болон бүс нутгийн хүний эрхийн хэм хэмжээ, механизм, тэдгээрийн хэрэглээ, парламентын үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөлөл, тэдгээрийг хууль тогтоомжид тусгах нь яагаад чухал болох талаар нэгдсэн ойлголтод хүрэх;
- Хүний эрх, жендэрийн эрх тэгш байдлыг хангах, хамгаалах парламентын үүрэг оролцоог идэвхжүүлэх, нэмэгдүүлэх;
- Хэрэгжүүлэх боломжтой алхам, тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих чадавхыг нэмэгдүүлэх зэрэг болно.

Дээр дурдсан зорилгыг хэрэгжүүлэх, хамтын ажиллагааны санамж бичгийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд УИХ-аас хүний эрх ба жендэрийн мэдрэмжийн асуудлаарх хоёр бие даасан үнэлгээг ОУПХ, НҮБ-ын Хүний эрхийн Дээд Комиссарын газар (ХЭДКГ) болон бусад байгууллагуудтай хамтран боловсруулсан аргачлалыг ашиглан зохион байгуулахаар шийдвэрлэсэн. Товчхондоо, өөрийн үнэлгээ нь Монгол Улсын Их Хурлыг хүний эрх, жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр илүү үр дүнтэй ажиллахад нь дэмжлэг үзүүлэх үндсэн зорилготой юм.

Ийнхүү хүний эрх, жендэрийн асуудлаар парламент өнөөгийн нөхцөл байдлаа дүгнэж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээгээ тодорхойлохоор парламентын өөрийн үнэлгээг 2023 оны 11 дүгээр сарын 22-23-ны өдрүүдэд Улаанбаатар хотод, Төрийн

¹ Парламентын жендэрийн мэдрэмжтэй байдал: өөрийн үнэлгээний аргачлал ОУПХ (2022)

ордонд зохион байгууллаа. УИХ нь хүний эрхийн өөрийн үнэлгээг зохион байгуулсан олон улс дахь анхны парламент болж байгаа бол жендэрийн мэдрэмжийн асуудлаарх өөрийн үнэлгээг зохион байгуулсан 13 дахь парламент болж байгаагаараа онцлогтой юм.

-ооо-

НЭГ. ҮНЭЛГЭЭНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

1.1. Үнэлгээний бэлтгэл ажил

Хүний эрх, жендэрийн асуудлаар парламентын өөрийн үнэлгээ (цаашид “өөрийн үнэлгээ” гэх)-г зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор УИХ-ын даргын 2023 оны 20 дугаар захирамжаар УИХ-ын гишүүдээс бүрдсэн, үнэлгээнд дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг УИХ-ын гишүүн, Хүний эрхийн дэд хорооны дарга Ц.Мөнхцэцэгээр ахлуулан байгуулсан. Түүнчлэн өөрийн үнэлгээг зохион байгуулах үүрэг бүхий УИХ-ын Тамгын газрын ажлын хэсгийг Эрх зүйн дүн шинжилгээ хариуцсан нэгжийн дарга Г.Агар-Эрдэнээр ахлуулан УИХ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын 2023 оны 637 дугаар захирамжаар байгуулж, уг ажлын хэсэг өөрийн үнэлгээг зохион байгуулах үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөөг гаргаж ажиллав. Өөрийн үнэлгээний үйл ажиллагаанд УИХТГ-т хэрэгжиж буй “Монгол Улсад парламентын ардчиллыг бэхжүүлэх нь” төсөл дэмжлэг үзүүлэв.

ОУПХ өөрийн үнэлгээний бэлтгэлийг хангахаас эхлэн үнэлгээг хийж дуусах хүртэлх хугацаанд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж хамтран ажиллав. Тухайлбал, өөрийн үнэлгээний зохион байгуулалт, чиглэл, аргачлалын талаарх үндсэн ойлголт, үйл явцын талаар танилцуулах зорилготой дараах сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулав.

1.“Парламент болон хүний эрхийн үндэсний байгууллагууд хоорондын харилцааны тухай Белградын зарчмууд”-ын талаарх хэлэлцүүлэг (2022.11.21). Хэлэлцүүлэгт УИХ-ын дэд дарга Л.Мөнхбаатар болон УИХ-ын гишүүд, УИХ-ын Тамгын газрын удирдлагууд, газар, хэлтсийн ажилтнууд, Хүний эрхийн Үндэсний Комисс (ХЭҮК), ОУПХ, Швейцарын хөгжлийн агентлагийн удирдлага, албан тушаалтнууд зэрэг 100 гаруй хүн танхимаар болон цахимаар оролцож холбогдох мэдээллийг солилцов.

2.“Жендэрийн мэдрэмжтэй, хүний эрхийг дээдэлсэн парламентыг төлөвшүүлэх парламентын өөрийн үнэлгээний бэлтгэл ажлыг хангах” цахим семинар (2023.04.05). Тус семинарт УИХ-ын гишүүн Б.Саранчимэг, Б.Жаргалмаа, Г.Тэмүүлэн, Ж.Бат-Эрдэнэ, Ц.Сандаг-Очир, УИХ-ын Тамгын газрын удирдлагууд, ОУПХ, ХЭҮК, Жендэрийн Үндэсний хороо (ЖҮХ)-ны 100 гаруй албан хаагч оролцсон.

3.“Хүний эрх, жендэрийн мэдрэмжтэй парламент: Өөрийн үнэлгээ” сэдэвт бэлтгэл хангах семинар (2023.09.27). Тус семинарт УИХ-ын Тамгын газрын удирдлага, албан хаагчид, ХЭҮК, ЖҮХ-ны төлөөлөл зэрэг нийт 113 хүн оролцсон.

Өөрийн үнэлгээг зохион байгуулахад зайлшгүй харгалзан үзэж хамтран ажиллах субъект нь тухайн асуудлаар мэргэшсэн, үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөхүйц мэдлэг, туршлага, боловсролтой үндэсний зөвлөх (шинжээч) нарыг томилох асуудал байв. Ийнхүү хүний эрх, жендэрийн асуудлаар тус бүр 2 үндэсний зөвлөхийг УИХ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын 2023 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн захирамжаар томилж ажиллуулав. Үүнд:

- Хүний эрхийн асуудлаарх парламентын өөрийн үнэлгээний үндэсний зөвлөхөөр Д.Гэрэл, Б.Болорсайхан,
- Жендэрийн асуудлаарх парламентын өөрийн үнэлгээний үндэсний зөвлөхөөр Б.Долгор, М.Батбаатар нар ажилласан болно.

УИХ-ын Тамгын газрын ажлын хэсэг үндэсний зөвлөхүүдтэй хамтран ОУПХ-ноос баталсан өөрийн үнэлгээний аргачлал тус бүрээс буюу хүний эрхийн асуудлаар 4 асуулт, жендэрийн асуудлаар 4 асуултыг тус тус сонгож энэ удаагийн парламентын өөрийн үнэлгээг явуулахаар шийдвэрлэсэн ба дараах асуултуудын хүрээнд боловсруулсан хөтөлбөрийн дагуу зохион байгуулагдсан болно. (Хавсралт 1)

Хүний эрхийн өөрийн үнэлгээний асуултууд	Жендэрийн асуудлаарх өөрийн үнэлгээний асуултууд
<ul style="list-style-type: none"> - Хүний эрхийн мэдрэмжтэй хууль тогтоох ажиллагаа - Парламентын хяналтыг бэхжүүлэх нь - НҮБ-ын хүний эрхийн тайлагнах механизмд парламентын оролцоог нэмэгдүүлэх нь - Олон нийт ба хүний эрхийн бусад байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх нь 	<ul style="list-style-type: none"> - Парламент дахь эмэгтэйчүүдийн оролцоо (тоо, албан тушаал) - Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хууль, эрх зүйн бодлого, тогтолцоо - Парламентад жендэрийн үзэл баримтлал нэвтрүүлэх нь - Парламент дахь жендэрийн соёл, орчин, бодлого

Сонгогдсон асуулт тус бүрийн хүрээнд мэдээлэл, лавлагааг УИХ-ын Тамгын газрын Парламентын судалгаа, сургалтын хүрээлэн (ПССХ)-гээс бэлтгэсэн болно. Мөн өөрийн үнэлгээнд оролцогчдод зориулсан тойм судалгаа бүхий гарын авлагыг бэлтгэж, өөрийн үнэлгээг зохион байгуулахаас 14 хоногийн өмнө оролцогчдод цаасан болон цахим хэлбэрээр тараав.

УИХ-ын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсээс хүний эрхийн болон жендэрийн асуудлаарх парламентын өөрийн үнэлгээний талаарх мэдээллийг бэлтгэж телевиз, сонин, УИХ-ын цахим хуудсаар түгээж ажиллав.

1.2. Үнэлгээний ерөнхий зохион байгуулалт

Өөрийн үнэлгээ нь “Парламент ба Хүний эрх”, “Парламентын жендэрийн мэдрэмжтэй байдал” өөрийн үнэлгээний аргачлалд тодорхойлогдсон асуултуудын хүрээнд нэгдсэн болон салбар хэлэлцүүлгийн хэлбэрээр 2 өдрийн турш явагдсан болно. Нэгдсэн хэлэлцүүлгийн үеэр үндсэн 7 илтгэл, салбар хуралдаануудын үед 8 илтгэл хэлэлцүүлээ. Үүнээс УИХ-ын гишүүд 9 илтгэл, УИХТГ 1 илтгэл, ХЭҮК 1 илтгэл, үндэсний зөвлөхүүд 2 илтгэл, ОУПХ-ны зөвлөх 2 илтгэл тус тус танилцуулав.

Үнэлгээний нэгдсэн хэлэлцүүлгийг УИХ-ын гишүүн, Хүний эрхийн дэд хорооны дарга Ц.Мөнхцэцэг удирдаж явуулсан бол салбар хэлэлцүүлгүүдийг хүний эрх, жендэрийн үндэсний зөвлөхүүд чиглүүлж ажиллав. Мөн салбар хэлэлцүүлэг тус бүрийн үр дүн, дүгнэлтийг нэгдсэн хэлэлцүүлэгт танилцуулж ажиллав.

Өөрийн үнэлгээний нээлтийн үйл ажиллагаанд УИХ-ын дарга Г.Занданшатар, ОУПХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга Мартин Чунгонг, Швейцарийн хөгжлийн агентлагийн захирал хатагтай Стефани Бурри нар мэндчилгээ дэвшүүлэв.

Эхний өдрийн нэгдсэн хэлэлцүүлэгт үндсэн илтгэлүүдийг УИХ-ын гишүүн, Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар “Хүний эрх, жендэр ба Монгол Улсын Их Хурал” сэдвээр, УИХ-ын Тамгын газрын тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат “Парламентын институц дэх хүний эрх, жендэрийн бодлого, хэрэгжилт” сэдвээр, ХЭҮК-ын дарга Ж.Хунан “Хүний эрхийн үндэсний байгууллага

болон парламентын хамтын ажиллагаа: Хүний эрх, жендэрийн эрх тэгш байдлын асуудлаарх олон улсын гэрээг хэрэгжүүлэх нь” сэдвээр танилцуулав.

Үндэсний зөвлөхөөр ажилласан Хүний эрхийн үндэсний зөвлөх, НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хорооны гишүүн Д.Гэрэл, Хүний эрхийн үндэсний зөвлөх, хүний эрх судлаач Б.Болорсайхан нар “Монгол Улс дахь хүний эрхийн бодлого, эрх зүйн орчин” сэдвээр, Жендэрийн үндэсний зөвлөх, Жендэрийн үндэсний шинжээч Б.Долгор, Жендэрийн үндэсний зөвлөх, МУИС-ийн Социологи, нийгмийн ажлын тэнхимийн эрхлэгч, Социологийн ухааны доктор (Ph.D) М.Батбаатар нар “Монгол Улс дах Жендэрийн эрх тэгш байдлын бодлого, эрх зүйн орчин” сэдвээр тус тус илтгэл танилцуулсан.

Үргэлжлүүлэн хүний эрх, жендэрийн мэдрэмжтэй парламентыг тодорхойлох нь, өөрийн үнэлгээнд бэлтгэх нь сэдвийн хүрээнд Олон улсын зөвлөх Мэг Мунн² ОУПХ-ны Жендэрийн хамтын ажиллагааны хөтөлбөрийн ажилтан Мариана Дуарте, ОУПХ-ны Хүний эрхийн хөтөлбөрийн ажилтан Ботанья Ламхарзи нар танилцуулга хийлээ.

8 удаагийн салбар хэлэлцүүлэгт УИХ-ын гишүүд сонгосон сэдвийн хүрээнд илтгэл танилцуулсан бөгөөд салбар хэлэлцүүлэг тухайлан боловсруулсан форматын дагуу тус бүр 1 цаг 30 минут үргэлжлэв (Хавсралт 2). Хүний эрх болон жендэрийн салбар хэлэлцүүлгүүдийг Олон улсын зөвлөх, хүний эрх жендэрийн асуудлаарх үндэсний зөвлөхүүд болон ОУПХ-ны мэргэжилтнүүд хамтран чиглүүллээ. Салбар хэлэлцүүлгүүдээс гарсан санал, зөвлөмжийг ПССХ-ийн ажилтнууд нэгдсэн хэлэлцүүлэгт танилцуулахад нэгтгэн бэлтгэсэн болно.

Өөрийн үнэлгээнд эмэгтэй 46, эрэгтэй 41, нийт 87 оролцогчид хамрагдсан. Үүнд: УИХ-ын гишүүд 12 (эмэгтэй 4, эрэгтэй 8), УИХ-ын Тамгын газрын ажилтнууд 41 (эмэгтэй 22, эрэгтэй 19), ХЭҮК-ын гишүүд, ажилтнууд 6, ЖҮХ 5, Төрийн албаны зөвлөл 1, Сонгуулийн ерөнхий хороо 2, ахмад парламентчид 5, иргэний нийгмийн төлөөлөл 7, мөн үндэсний зөвлөхүүд 4 болно. Бүлгийг хүйсийн хувьд тэнцвэртэй байхаар тооцож сонгосон бөгөөд УИХ-ын гишүүдийн хувьд сонгогдсон тойрог буюу орон нутаг, нас, улс төрийн намын гишүүнчлэл зэргийг давхар харгалзан үзсэн болно.

1.3. Үнэлгээний урьдчилсан үр дүнг танилцуулсан байдал

Үнэлгээний урьдчилсан үр дүнг танилцуулах хэвлэлийн бага хурлыг 2023 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр Төрийн ордонд зохион байгуулж үндэсний зөвлөхүүд болон ОУПХ-ны төлөөлөл оролцож, хэвлэл мэдээлэл, сэтгүүлчдийн асуултад хариулав.

Мөн НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газрын Ази, Номхон далайн бүс нутаг хариуцсан Албаны дарга Рори Мунговен, Монгол Улсыг хариуцсан ажилтан Себастен Гиёо нар 2023 оны 12-р сарын 04-08-ны өдрүүдэд Монгол Улсад ажиллахдаа уг үнэлгээний үр дүнгийн талаар уулзах хүсэлт тавьсны дагуу 2023 оны 12 дугаар сарын 6-ны өдөр УИХТГ-ын ажлын хэсгийг төлөөлж Хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, төслийн зохицуулагч С.Алтанхуяг нар байлцаж, үнэлгээний талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөв.

² Английн парламентын гишүүн асан, Засгийн газрын сайд асан

ХОЁР. ҮНЭЛГЭЭНИЙ САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Үндэсний зөвлөхүүд парламентын өөрийн үнэлгээнд тавигдсан илтгэл, танилцуулга, оролцогчдын гаргасан санал зэрэг дээр тулгуурлан хүний эрх, жендэрийн асуудлаар парламент, түүний Тамгын газраас авч хэрэгжүүлбэл зохих арга хэмжээний талаарх санал, зөвлөмж гаргасныг танилцуулж байна.

2.1. Хүний эрхийн асуудлаарх санал, зөвлөмж

Хүний эрхийн үндэсний зөвлөх Д.Гэрэл, Б.Болорсайхан нар дараах дөрвөн сэдвийн дагуу дүгнэлт, зөвлөмжийг боловсруулав.

Хүний эрхийн мэдрэмжтэй хууль тогтоомж гэдэгт аливаа улсын хууль тогтоох эрх мэдлийн зүгээс хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ялангуяа нийгмийн эмзэг бүлгээ эн тэргүүнд тухайлан хамгаалах, гүйцэтгэх эрх мэдлийн гол үүрэг болсон хүний эрхийн талаарх зөвлөмжийг хэрэгжүүлэхэд хяналт тавих зэрэг арга замаар хүний эрхийн хэм хэмжээ, жишгийг бодит биелэл болгодог байх, тэдгээрийг амьдралд хэрэгжүүлэхэд үүссэн зааг ялгааг арилгах, хүний эрхийн биелэлтэд эерэг нөлөө үзүүлэх, ахиц дэвшил гаргах зорилготой хууль тогтоомж гэж илтгэгч, оролцогч бүр цохон тэмдэглэлээ.

Үнэлгээнд оролцогчдын зүгээс хууль тогтоомж, бодлого шийдвэрийн бодит хэрэгжилт чухал төдийгүй хөгжил, хүний эрхэд ч хамаатай болохыг удаа дараа онцолсон бөгөөд хяналт-шинжилгээ, үнэлгээ, сурах үйл явц нэгэн зэрэг өрнөхгүй байгааг онцлов.

Нийгмийн бүлгийн хэрэгцээ, ялгаатай байдал, тэдэнд тулгамдсан асуудлыг нэг этгээд сайтар судлах нөхцөл боломжгүй учраас илүү бүтээлчээр хамтын оролцоог хөхиүлэн дэмжих, оролцогч талуудыг тэгш хамруулсан, утга учиртай оролцоог зөвхөн цахим хэмээн нэг хэлбэрээр хязгаарлахгүй, биет, нүүр тулсан байхаас холимог, цаашилбал шууд, цахим хэлбэрээр хийх олон сонголтот, боломжийг бүрдүүлэх талаар санал нэгдлээ.

Учир нь хүний эрхэм чанарыг хүндэтгэх, үл ялгаварлах, эрх тэгш байдлыг хангах нь төрийн эн тэргүүний хүлээх үүрэг бөгөөд хүний эрхийг хамгаалах тогтолцооны бүрэлдэхүүн – УИХ нь бусад төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагад Үндсэн хуульд заасан ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх үндсэн зарчмыг хөдөлбөргүй, чигч, нэг мөр хэрэгжүүлж үлгэрлэвэл зохино. Үүнийг анхаарч ажиллахын тулд дор дурдсан арга хэмжээ авахыг зөвлөж байна.

I. Хүний эрхийн мэдрэмжтэй хууль тогтоох үйл ажиллагаа

Монгол Улсын Их Хурал:

1. Тухайлан үүрэг хүлээсэн албан ёсны бүтэц бий болгох зорилгоор УИХ-ын Хүний эрхийн байнгын хороо, түүний дор Жендэрийн дэд хороо, Тогтвортой хөгжлийн дэд хороо байгуулах;

2. Байнгын хороодын дунд чиг үүргийн давхцал үүсэхээс сэргийлж, хууль зүйн үндэсний бодлого тодорхойлох, боловсруулах, энэхүү үйл явцын Үндсэн хуультай нийцэж байгааг тусгайлан хариуцах, Үндсэн хуулийн цэцэд парламентыг тухайлан төлөөлөх, хууль тогтоох эрх мэдлийн хүрээнд хууль дээдлэх ёсыг чанд дагахад

манлайлж ажиллах чиг үүрэгтэй Хууль зүйн байнгын хороо болон хүний эрх, эрх чөлөөг хангах, эдлэхүйц таатай нөхцөл, боломжийг тодорхойлох, НҮБ-ын хүний эрхийн механизмд парламентын оролцоог хангах, төлөөлөх, жендэрийн эрх тэгш байдал, тогтвортой хөгжил зэрэг үл ялгаварлах, эрх тэгш байх зарчмын хүрээнд хөгжих эрхийн асуудлыг Хүний эрхийн байнгын хороонд хариуцуулах;

3. Хүний эрхийн байнгын хороо жил бүр Магадлан итгэмжлэх дэд хорооны зөвлөмжийн хэрэгжилт, Парисын зарчимд ХЭҮК нийцэн ажиллаж байгаа талаар сонсгол хийх;

4. Олон улсын гэрээний дагуу хүлээсэн үүргээ төрийн байгууллага биелүүлэхүйц төсвийг хангалттай, хүрэлцэх хэмжээгээр хуваарилах;

Монгол Улсын Их Хурлын Тамгын газар:

5. Монгол Улсын Засгийн газрын байгуулсан зөвлөл, хороодын оролцоотой “Тогтвортой хөгжлийн үр шим хүртэж чадахгүй байгаа нийгмийн гадуурхагдсан, адлагдсан, хавчигдсан бүлэгт үзүүлэх нөлөөг тодорхойлох аргачлал”, “Хүний эрхэд суурилсан, жендэрийн мэдрэмжтэй, насанд тохирсон, тэгш хамарсан төсөвлөлт”, “Хүний эрхийн шалгуур үзүүлэлт бүхий хууль тогтоомжийн үр нөлөөний үнэлгээ” зэрэг аргачлал боловсруулан нэвтрүүлэх;

6. УИХ-ын гишүүний гарын авлагыг сайжруулж, хүний эрхийн үндсэн зарчим, хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцоо, олон улсын хүний эрхийн гэрээ, НҮБ-ын гэрээний хороодоос гаргасан ерөнхий зөвлөмж, хүний эрхийн механизм дахь оролцоо, тайлагнах товцоо зэрэг бусад шаардлагатай мэдээлэл, эх сурвалж агуулсан бүлэг нэмэх;

7. ОУПХ, НҮБ-ын хамтран боловсруулсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцын талаар парламентчдад зориулсан гарын авлага”-ыг монгол хэлнээ орчуулж, УИХ-ын гишүүд, тэдний зөвлөх, ажлын албаны ажилтны хэрэглээнд нэвтрүүлэх;

8. Хүүхэд, өсвөр үеийнхэн; хөдөөгийн ядуу иргэд; үндэстний цөөнх; ажилгүй, ур чадваргүй залуус; охид, эмэгтэйчүүд болон эмзэг бүлгийн эрчүүд; хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс; ахмад настан; хот, суурин газрын ядуу иргэд, дотоодын шилжин суурьшигчид; бэлгийн цөөнх; хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид зэрэг хөгжлийн үр шим хүртэж чадахгүй байгаа болон байх магадлалтай нийгмийн бүлгийн асуудлаар сургалтыг тухайн бүлгийн эрхийн чиглэлээр ажилладаг иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран явуулдаг тогтолцоог бий болгох, сэдэвчилсэн сургалтын модуль, багц хамтран боловсруулах;

9. УИХ-ын гишүүд, тэдний зөвлөх, ажлын албаны ажилтнуудад, мөн Тамгын газрын шинэ ажилтнуудад хүний эрх, жендэрийн талаар үндсэн сургалт, ахисан түвшний сургалт, гүнзгийрүүлсэн сургалт дэс дараатай ээлжлэн зохион байгуулах;

10. Хүүхэд, өсвөр үеийнхэн; хөдөөгийн ядуу иргэд; үндэстний цөөнх; ажилгүй, ур чадваргүй залуус; охид, эмэгтэйчүүд болон эмзэг бүлгийн эрчүүд; хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс; ахмад настан; хот, суурин газрын ядуу иргэд, дотоодын шилжин суурьшигчид; бэлгийн цөөнх; хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид зэрэг хөгжлийн үр шим хүртэж чадахгүй байгаа болон байх магадлалтай нийгмийн бүлгийн асуудлаар жил бүр тоо баримт, тохиолдол цуглуулж, мэдээллийн санг баяжуулах, энэ чиглэлээр мэргэшсэн судлаачидтай болох;

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс:

11. Магадлан итгэмжлэх дэд хорооны зөвлөмжийн хэрэгжилт, Парисын зарчимд ХЭҮК нийцэн ажиллаж байгаа талаар Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 2024 оны илтгэлийн нэг бүлэгт тухайлан илтгэж, цаашид жил бүр хэвших;

12. Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилт, тэр дундаа тогтвортой хөгжлийн үр шим хүртэж чадахгүй байгаа нийгмийн гадуурхагдсан, адлагдсан, хавчигдсан бүлгийн хүний эрхийн төлөв байдлыг 2030 он хүртэл тасралтгүй хөндлөнгийн, хараат бус байдлаар илтгэх;

13. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хууль тогтоомжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх илтгэлийг сэдэвчилсэн илтгэл байдлаар тусад нь боловсруулах;

14. Ахмад настны эрхийн тухай конвенц боловсруулан, батлуулах бүсийн болон олон улсын санаачилгыг судалж, саналаа холбогдох этгээдэд хүргүүлэх;

II. Парламентын хяналтыг бэхжүүлэх нь

Монгол Улсын Их Хурал:

15. ХЭҮК-ын жил бүр хүргүүлдэг илтгэлийг тухайн жилийн 4 дүгээр сард багтаан УИХ хэлэлцэж, холбогдох тогтоолоо баталж хэвших. Бүтцийн болон тогтолцооны шинжтэй хүний эрхийн асуудлыг шийдвэрлэх тухай тогтоолдоо 12-24 сарын товцоо тогтоох;

16. Хууль зүйн байнгын хороо, УИХ-ын Тамгын газар хамтран Олон улсын гэрээний хэрэгжилтийн тухай хуулийн үр дагаварт үнэлгээ 2024 оны I улиралд багтаан хийж, танилцуулахыг даалгах;

17. Олон улсын гэрээний үүргийн хэрэгжилтийн талаарх УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны Ажлын хэсгийн³ тайлангийн мөрөөр Засгийн газар зарцуулж, хүний эрхийн механизмын зөвлөмжийг хэрэгжүүлэх төсвийг тооцоолон, үүрэг хүлээгч – холбогдох төрийн байгууллагад хангалттай хэмжээгээр хуваарилах;

18. Хүний эрхийг хангах Үндэсний Хорооны санаачилга, шийдвэрийн дагуу ХЭҮК-ын манлайлал дор боловсруулсан “Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний 2024-2034 оны төлөвлөгөө”-г хэлэлцэн батлах, жил бүр Хүний эрхийн байнгын хороогоор хэрэгжилтийг хэлэлцэж хэвших;

19. УИХ-ын Тамгын газрын алба хаагчдын тоог нэмэгдүүлэх, ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, мэргэших, чадавхжих, асуудлыг тал бүрээс бүрэн дүүрэн шинжлэх ухаанч байдлаар ажиллах нөхцөл бүрдүүлэх;

III. Нэгдсэн Үндэстний Байгууллагын хүний эрхийн тайлагнах механизмд парламентын оролцоог нэмэгдүүлэх нь

Монгол Улсын Их Хурал:

20. Хууль зүйн байнгын хороо, Хүний эрхийн дэд хороо олон талын төлөөлөл бүхий өргөн бүрэлдэхүүнтэйгээр Олон улсын гэрээний үүргийн хэрэгжилтийн талаарх УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны Ажлын хэсгийн⁴ тайлангийн үр дүнтэй танилцаж, Хууль зүйн байнгын хороогоор уламжлан нэгдсэн хуралдаанаар 2024 оны I улиралд хэлэлцүүлэх;

21. Нэгдсэн хуралдаанаас НҮБ-ын хүний эрхийн механизмын зөвлөмжийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай УИХ-ын тогтоол 2024 оны I улиралд гаргуулж, Засгийн газрын эгэх хариуцлагыг нэмэгдүүлэх;

22. Олон улсын гэрээний хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор УИХ-ын Хүний эрхийн байнгын хороо, шаардлагатай тохиолдолд асуудал хамаарсан холбогдох Байнгын хороодоор хүний эрхийн гэрээний хэрэгжилтийн тайлангийн төсөл хэлэлцдэг байх;

³ Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 9 дүгээр тогтоолоор байгуулсан.

⁴ Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 9 дүгээр тогтоолоор байгуулсан.

23. Монгол Улсын Засгийн газрын Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийн тайлан – Сайн дурын үндэсний илтгэлийг Хүний эрхийн байнгын хорооны Тогтвортой хөгжлийн дэд хороогоор хэлэлцэж, Засгийн газрын хэлэлцүүлгийн мөрөөр НҮБ-д илгээж хэвших;

24. Засгийн газраас Монгол Улсын нэгдэн орсон хүний эрхийн олон улсын зарим гэрээ, конвенцын цөөнгүй нэр томъёоны монгол орчуулгыг эргэн хянах, боломжит хүрээнд оновчтой болгохыг шаардах;

25. Монгол Улсын Засгийн газар хүлээсэн үүргээ биелүүлж, нэгдэн орсон гэрээдийн ерөнхий тайлбар, илгээсэн тайлан, мэдээ, түүний дагуу хүлээн авсан дүгнэлт, зөвлөмж, ажиглалт нэг бүрийг албан ёсоор монгол хэлнээ орчуулж, хэрэглээнд нэвтрүүлэх, “Төрийн мэдээлэл” сэтгүүлд хэвлүүлэх, Эрх зүйн мэдээллийн нэгдсэн системээр (www.legalinfo.mn) түгээхийг шаардах;

IV. Олон нийт ба хүний эрхийн бусад байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх нь

Монгол Улсын Их Хурал:

26. Иргэд, олон нийт, сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнууд Төрийн ордонд нэвтрэхэд шаардаж байгаа, ялгаварлан гадуурхалтын шинжтэй хувцасны шалгуурыг холбогдох журмаас даруй хасах. Тодруулбал, 2000 оны албаны бус хувцас (жинсэн өмд, цамцтай, богино болон хагас задгай банзалтай, биеийн тамирын хувцас) 2018 оны биеийн тамирын, чөлөөт амралтын, ажлын болон этгээд загварын, нуруу, хэнхдэг ил гарсан, гэрэлтдэг нимгэн хувцас, өвдөгнөөс дээш богино банзал, бохирдсон хувцас, 2023 оны нуруу, хэнхдэг ил гаргасан, гэрэлтдэг нимгэн хувцас;

27. УИХ-ын Байнгын болон дэд хорооны, ажлын хэсгийн, хэлэлцүүлгийн, чуулганы хуралдааны бичлэгийг үг хэлж байгаа хүний дүрсээр хязгаарлахгүй, танхимын дүрс бичлэгийг бүхэлд нь тусгайлан дамжуулж хэвших;

28. Хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнуудад УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдааны танхимд зураг, дүрс авах боломжоор эрх тэгш хангах;

29. УИХ-ын Тамгын газар, Ерөнхийлөгчийн Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын зүгээс Төрийн ордонд ажиллаж байгаа алба хаагчдад зориулан Алсын зайнаас ажиллах журам, Ялгаварлан гадуурхалт болон бэлгийн дарамтаас сэргийлэх, түүнийг шийдвэрлэх журам, Хүүхэд хамгааллын журам, Байгаль орчинд ээлтэй бодлого хэрэгжүүлэх журам, Шүгэл үлээх журам, Хөгжлийн бэрхшээлтэй хүний оролцоог хангах, тэгш хамрах журам, Хандив, тусламжийг бүртгэх журам батлах;

30. НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг тэгш хамруулах, оролцоог дэмжих стратегиас үлгэрлэн, УИХ болон Засгийн газарт зориулсан үлгэрчилсэн журам, хариуцан гүйцэтгэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах;

31. Аливаа хууль тогтоомжийн төсөл боловсруулах, парламентын хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх хүрээнд зохион байгуулж байгаа сонсгол, хэлэлцүүлэг гэх мэт үйл ажиллагаанд иргэний нийгмийн байгууллагуудыг оролцуулахдаа хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон бусад орхигдох магадлалтай бүлгүүдийн эрхийг хамгаалах чиглэлд ажилладаг иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог тэгш хангах зорилгоор тэдгээр байгууллагуудын жагсаалт, сан бүрдүүлж, тэдний оролцоог бодитой, үр дүнтэй, утга учиртай хангаж ажиллах;

Монгол Улсын Их Хурлын Тамгын газар:

32. УИХ-ын гишүүдийн ирцийг шууд, бодитой шинэчлэн үздэг болгох;

33. Төрийн ордны барилга байгууламжийн саадгүй байдал, хүртээмжийн талаарх үнэлгээг мэргэшсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудтай хамтран хийх. Үнэлгээний мөрөөр цаашид түгээмэл загварын дагуу парламентын

орчинг цогцоор нь ээлтэй, таатай орчин болгох зорилгоор хүртээмжийг сайжруулах төлөвлөгөө боловсруулан хамран ажиллах;

34. УИХ-ын мэдээлэл түгээх, олон нийттэй харилцах асуудал хариуцсан ажилтнуудад хүртээмжтэй мэдээллийн талаар сургалт явуулах;

35. ПССХ сар бүрийн сүүлийн лхагва гарагт хүний эрхийн чиглэлээр мэргэшсэн шинжээч, хүний эрх хамгаалагч, төрийн болон төрийн бус байгууллагууд оролцсон дугуй ширээний цахим уулзалт зохион байгуулж, хүний эрхийн тулгамдсан асуудлын талаар хэлэлцэх, харилцах, мэдээлэл солилцох суваг болгож ажиллуулах;

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс:

36. ПССХ сар бүрийн сүүлийн лхагва гарагт зохион байгуулах дугуй ширээний цахим уулзалтад Иргэний нийгмийн зөвлөл, Хүний эрх хамгаалагчийг хамгаалах хорооны мэдээлэл хуваалцаж хэвших.

2.2. Жендэрийн асуудлаарх санал, зөвлөмж

Жендэрийн үндэсний зөвлөх Б.Долгор, М.Батбаатар нар дараах дөрвөн сэдвийн дагуу дүгнэлт, зөвлөмжийг боловсруулав.

I. Парламент дахь эмэгтэйчүүдийн оролцоо (тоо, албан тушаал)

1.1. УИХ дахь эмэгтэй гишүүдийн тооны талаар

Өнөөгийн нөхцөл байдал, ахиц дэвшил

1992 онд батлагдсан ардчилсан, шинэ Үндсэн хуулиас хойш УИХ-ын 8 удаагийн сонгууль зохион байгуулагдсан бөгөөд эдгээр сонгуульд нийт 3445 хүн нэр дэвшсэнээс 577 эмэгтэй нэр дэвшиж, 65 эмэгтэй УИХ-ын гишүүнээр сонгогдсон байна. УИХ-ын 1992 оны сонгуульд 3 эмэгтэй сонгогдож, 3.9%-ийг эзэлж байсан бол 1996, 2000 онд 8-9 эмэгтэй сонгогдож, 2004, 2008 онуудад 5, 3 болон эрс буурсан. 2012 онд нам эвслээс нэр дэвшигчийн 20%-иас доошгүйн хүйсийн квотыг тогтоон, сонгуулийг холимог системээр явуулснаар 11 эмэгтэй /6 нь тойргоос, 5 нь намын жагсаалтаас/ сонгогдож, 14.5%-ийн суудлыг эзэлсэн. Мөн 2016, 2020 оны сонгуульд хүйсийн квотыг нэмэгдүүлээгүй бөгөөд тус тус 13 эмэгтэй сонгогдож, 17.1%-ийг эзлэн, өөрчлөлт гараагүй байна. Энэ нь дэлхийн улс орнуудын дунджаас 7.6%-иар бага бөгөөд дэлхийн хэмжээнд тус улс 134-т жагсаж байна.

Харин Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийг 2023 онд шинэчлэхдээ 2024 оны сонгуулиар нам, эвслээс нэр дэвшигчийн 30-аас доошгүй хувь нь, 2028 оны сонгуулиар 40-өөс доошгүй хувь нь аль нэг хүйсийнх байх, жагсаалтаар нэр дэвшигчдийг хүйсийн хувьд 1/1 байдлаар байршуулах, мөн сонгуулийн зардлыг багасгах зарим зохицуулалтыг хуульчилсан нь нааштай нөлөө үзүүлэх боломжтой. Мөн Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулга/2023/-аар намын удирдах бүрэлдэхүүнд аль нэг хүйсийн төлөөлөл 40%-иас доошгүй байх, сонгуульд нэр дэвших эрх олгохдоо барьцаа, дэнчин зэргийг шаардах, авахыг хориглох; төрийн санхүүжилтийн 20-иос доошгүй хувийг эмэгтэй, ...хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрийн оролцоог дэмжих, сургаж бэлтгэх; хүйсийн квотоос илүү нэр дэвшүүлсэн эмэгтэй улс төрчийн тоонд нэмэлт санхүүжилт олгох, ЖЭТБХТХ-д заасан тайланг өгөөгүй намын төрийн санхүүжилтийг ЖҮХ-ны дүгнэлтийн дагууд зөрчлийг арилгах хүртэл зогсоох зэрэг жендэрийн агуулга бүхий нааштай зохицуулалт хийсэн юм.

УИХ дахь эмэгтэй гишүүдийн тоонд нөлөөлж буй хүчин зүйлс, саад бэрхшээл

Анх 2005 онд УИХ-аас Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтыг батлахдаа 2015 он гэхэд улс төр, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог 30 хувьд хүргэх зорилт тавьсан ч бодит байдалд хэрэгжээгүй. 2005 оны Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиар 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсэгт “Нам эвслээс нэр дэвшигчдийн 30-аас доошгүй хувь нь аль нэг хүйсийнх байх” гэсэн заалт баталсан боловч уг заалтыг 2007 онд шууд цуцалж, ямар ч квотгүй болгосон. Үүний улмаас 2008 оны сонгуульд зөвхөн 3 эмэгтэй сонгогдсон. 2011 онд УИХ-аас квотыг 20%-иар баталж, энэ квотыг нэмэгдүүлээгүй өнөөг хүрсэн. Мөн улс төрийн намууд нэр дэвшүүлэхдээ квотыг хамгийн доод түвшинд хангах байдлаар хэлбэр төдий хэрэгжүүлдэг. Түүний дотор эрэгтэйчүүдийг илүү найдвартай тойрогт хуваарилдагтай холбоотой. УИХ-д эмэгтэйчүүд сонгогдох байдал нь тухайн сонгуульд олон буюу олонхийн суудал авсан намаас нэр дэвшсэн эмэгтэйчүүдийн тооноос шалтгаалдаг. Сүүлийн үед шинэ намууд эмэгтэйчүүдийг олноор нэр дэвшүүлж байгаа боловч тэдгээр нам УИХ-д суудал аваагүй, эсвэл цөөн суудал авсан. УИХ-ын сонгуулийн дээрх квот нь зөвхөн нэр дэвшигчийн хүйсийн төлөөллийн доод хэмжээ бөгөөд суудал хадгалах квот биш учир тойрогт нэр дэвшсэн эмэгтэйчүүд олноор сонгогдох магадлал багатай.

Улс төрд бизнесийн ашиг сонирхлын нөлөө их, томоохон компаниуд сонгуулийг санхүүжүүлдэг, нам дотроо нэр дэвших эрх авахад “нэр дэвшигчийн татвар” гэх их хэмжээний мөнгөний босго тавьдаг, сонгуулийн зардал асар их, 2016 онд нэг нэр дэвшигчийн зардлын дээд хэмжээ 322 сая төгрөг байсан бол 2020 онд 410 сая төгрөг болж нэмэгдсэн зэрэг нь голдуу хөрөнгөлөг хүмүүс сонгогдох нөхцлийг бүрдүүлсэн.

Тэрчлэн төрийн жинхэнэ албан хаагч нэр дэвших нөхцөлд сонгуулийн жилийн эхнээс төрийн албанаас чөлөөлөгдсөн байх хязгаарлалт тавьдаг нь төрийн албаны туршлагатай удирдах албан хаагчид нэр дэвших боломжийг хааж, ингэснээр эргээд хөрөнгөлөг бизнесмен олноор сонгогдоход хүргэсэн.

Нэр дэвшилтэд үндсэндээ мөнгөний шалгуур үйлчилж, зөөлөн ур чадвар, ёс зүйн шаардлагыг орхигдуулж, нэр дэвшүүлэх тодорхой шалгуур тавихгүй байгаа нь эмэгтэйчүүд нэр дэвших сонгогдоход сөргөөр нөлөөлдөг.

Тэрчлэн Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль /2020/-иар тогтоосон нэр дэвшигчийн 20-иос доошгүй хувийн квотыг нэмэгдүүлээгүй байгаа нь төлөөлөгчдийн тоо хүрсэн түвшнээс ухрах магадлал ихтэй.

УИХ дахь эмэгтэй гишүүдийн төлөөллийг нэмэгдүүлэхийн тулд хийж хэрэгжүүлэх зүйлс:

1. Улс төрийн намын, УИХ-ын болон орон нутгийн сонгуулийн тогтолцоо, албан тушаалын томилгоо, нэр дэвшилтийн мөнгөнөөс хараат байдлыг зогсоож, голчлон хөрөнгөлөг хүмүүс сонгогдож томилогддог нөхцлийг өөрчилж, ёс зүйн өндөр шалгуурыг хуульчилж, 2028 оноос хэтрэхгүйгээр хүйсийн төлөөллийг тэнцвэржүүлэх.
2. Нэн тэргүүнд сонгуульд нэр дэвшүүлэх хүйсийн квотыг дээд хязгаар болгон буруугаар хэрэгжүүлж ирсэн алдааг засаж, доод хязгаараас дээш аль болох олон эмэгтэйг нэр дэвшүүлэх, ялангуяа тухайн нам ялах боломжтой тойрогт эмэгтэйчүүдийг нэр дэвшүүлэх, бүсчилсэн байдлаар зохицуулалт хийх.

3. Улс төрийн намууд сонгуулийн зардлыг боломжит хамгийн бага түвшинд байлгах бодлого явуулж, үйл ажиллагааны зохицуулалт хийж, эмэгтэй нэр дэвшигчид санхүүгийн тусгайлсан дэмжлэг үзүүлэх.
4. Улс төрийн намууд нэр дэвшилтэд төрийн албанд ажилласан туршлага, зөөлөн ур чадвар, ёс зүйн шаардлагыг гол шалгуур болгох, төрийн удирдах албан хаагч эмэгтэй болон эрэгтэйчүүдээс жагсаалтын эхэнд нэр дэвшүүлэхэд анхаарах.
5. Төрийн жинхэнэ албан хаагч нэр дэвшихэд саад болж байгаа зохицуулалтыг Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтэд нийцүүлэн өөрчилж, төрийн албаны мерит зарчмыг улс төрийн албанд бодитоор хэрэгжүүлэх нөхцлийг хангах.
6. Улс төрийн намд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдтэй санхүүгээр биш мэдлэг, туршлагаар өрсөлдөх тэгш гараанаас гарах шударга тогтолцоог бий болгох.
7. УИХ-д хүйсийн тэнцвэрийг хангахын тулд цаашид тойрогт эмэгтэй, эрэгтэйчүүдийг адил тоогоор нэр дэвшүүлэх хэвтээ квотыг хэрэглэх, эсвэл хувь тэнцүүлсэн тогтолцоонд бүрэн шилжих замаар хүйсийн 1/1 харьцааг хэрэгжүүлэх.
8. Эмэгтэйчүүдийг олноор нэр дэвшүүлэх нь улс төрийн нам сонгуульд амжилт гаргах чухал хэрэгсэл болох тул энэ боломжийг намууд ашиглах, сонгуулийн мөрийн хөтөлбөртөө жендэрийн асуудлыг тусгах.
9. Улс төрийн намын тухай хуульд заасан, намын төв, орон нутгийн удирдах байгууллагад эмэгтэйчүүдийн 40%-иас дээш квотыг бодитой хангаж, 2024 оны сонгуулиас өмнө удирдлагын гол гол албан тушаалд эмэгтэйчүүдийг томилж үйл ажиллагааг явуулах.
10. Улс төрийн намууд сонгуульд нэр дэвших боломжтой эмэгтэйчүүдийг сургах бэлтгэх чадавхжуулах үйл ажиллагааг хуульд заасан хэмжээний хөрөнгө мөнгийг зарцуулан зохион байгуулах болон удирдах албан тушаалтныг жендэрийн сургалтад хамруулах.
11. Эмэгтэйчүүдийг сонгохын эсрэг, улс төрч эмэгтэйчүүдийн эсрэг хэвлэл мэдээллээр түгээж байгаа үзэл санаа буюу жендэрийн хэвшмэл ойлголтыг арилгах, түүнд чиглэсэн сургалт нөлөөллийн ажлыг явуулахад улс төрийн намууд хуульд заасан эх үүсвэрийг зарцуулах, түүнд Сонгуулийн ерөнхий хороо хяналт тавьж ажиллах.
12. Сонгуулийн ерөнхий хорооноос сонгогчдын боловсролын үйл ажиллагааг жендэрийн мэдрэмжтэй явуулах, цаашид энэ чиглэлд сонгуулийн бус жилд зарцуулах санхүүжилтийг шийдвэрлэх.
13. Сонгуулийн ерөнхий хороонд жендэрийн мэдрэмжтэй сонгуулийн үйл явцыг хангахад шаардагдах эрх хэмжээ олгох.
14. УИХ-д төлөөлөл багатай хүн амын бусад бүлэг, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн төлөөллийг сайн хангах, тэдэнд зориулсан сургалт нөлөөллийн ажил, сонгуульд санал өгөх боломжийг бүрдүүлэх.
15. Соёл, урлаг, сэтгүүлч, зохиолчдын байгууллагын хэвлэл мэдээлэл, олон нийтийн соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд жендэрийн агуулга нэвтрүүлж, тэдгээрт аудит хийх, ажиглах, гажуудлыг арилгахад дэмжлэг үзүүлэх.
16. ИНБ-ууд, улс төрийн намын дэргэдэх эмэгтэйчүүдийн байгууллагын хамтын санал санаачлага болон эрэгтэй, эмэгтэйчүүдийн түншлэлийг бий болгох.
17. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд нэр дэвшигчийн хүйсийн квотыг 40-50% болгон нэмэгдүүлэх замаар бүх шатны ИТХ-ын Төлөөлөгчдөд хүйсийн тэнцвэрийг хангах.
18. Улс төрийн хүрээн дэх жендэрийн эрх тэгш байдлыг хангахын тулд эдийн засгийн, өмчлөлийн, шийдвэр гаргалтын болон бусад эрх тэгш байдлыг хангахад цогцоор анхаарч, Аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн эдийн засаг дахь оролцоог нэмэгдүүлэх тухай хуулийн төслийг дэмжин баталж мөрдүүлэх.

1.2.УИХ дахь эмэгтэй гишүүдийн албан тушаалын талаар

Өнөөгийн нөхцөл байдал, ахиц дэвшил

1992-2020 онд зохион байгуулсан 8 удаагийн УИХ-ын сонгуульд нийт 570 эмэгтэй нэр дэвшиж, давхардсан тоогоор 65 эмэгтэй сонгогджээ. 1992 оноос хойш УИХ-ын даргаар нийт 12 хүн ажилласнаас УИХ-ын даргаар нэг ч эмэгтэй сонгогдоогүй, УИХ-ын дэд даргаар хоёр эмэгтэй, УИХ дахь нам, эвслийн бүлгийн даргаар нэг эмэгтэй ажиллаж байв. Байнгын хорооны даргаар нийт 139 хүн ажилласнаас 18 нь эмэгтэй, дэд хорооны даргаар нэг эмэгтэй ажиллаж байна. Байнгын хорооны даргаар ажилласан 18 эмэгтэйн 8 нь нийгмийн болон боловсролын бодлогын байнгын хорооны даргаар ажилласан байна. УИХ-ын эмэгтэй гишүүдийн Байнгын хороонд харьяалагдсан байдлыг авч үзвэл, боловсрол, нийгэм, байгаль орчны чиглэлийн байнгын хороодод түлхүү харьяалагдаж байгаа бол төсөв, эдийн засаг, төрийн байгуулалт, аюулгүй байдлын чиглэлийн байнгын хороодод эмэгтэйчүүдийн төлөөлөл цөөн буюу 1-2 төлөөлөлтэй байна. Түүнчлэн УИХ-ын Хууль зүйн болон Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороонд одоогоор нэг эмэгтэй гишүүний төлөөлөл байна. УИХ-ын Ерөнхий нарийн бичгийн даргаар нэг эмэгтэй ажилласан бөгөөд УИХ-ын Тамгын газрын 18 газар, хэлтсийн даргын 7 нь буюу 38.8% нь эмэгтэй байна.

Нөлөөлж буй хүчин зүйлс, саад бэрхшээл

УИХ-ын удирдлага, Байнгын болон бусад хороодын удирдлагыг сонгох асуудлаар УИХ-ын тухай хуулиудад жендэрийн асуудлыг анхаарах, хүйсийн харьцааг харгалзах талаар ямар нэгэн зохицуулалт байхгүй. Эдгээр асуудлыг эрх баригч намын удирдлага, УИХ дахь намын бүлгийн бодлогоор шийдвэрлэдэг. Эдгээр эрх мэдэлтнүүд бараг бүхэлдээ эрэгтэйчүүдээс бүрддэг.

УИХ-ын удирдлагад эзлэх эмэгтэй гишүүдийн хувийг нэмэгдүүлэхийн тулд хийж хэрэгжүүлэх зүйлс:

1. УИХ-ын удирдлага, хороодын удирдлагыг сонгоход хүйсийн квотыг 40%-иас доошгүйгээр тогтоох.
2. Хороодод гишүүдийг хуваарилах, УИХ дахь намын бүлгийн удирдлагыг сонгоход болон ажлын хэсэг зэрэг үйл ажиллагааны бүтцийн бүрэлдэхүүнд, сонсгол зэрэг аливаа хуралдааныг даргалахад хүйсийн харьцааг харгалзах.
3. УИХ болон удирдлага дахь эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэхэд нөлөөлөл үзүүлэх, хяналт тавих, тайлагнах хяналтын үүргийг тодорхой нэгжид харьяалуулах.
4. УИХ-ын Тамгын газрын удирдах албан тушаалд хүйсийн квотыг 40%-иас доошгүйгээр тогтоох.
5. УИХ-ын Ерөнхий нарийн бичгийн даргаар эмэгтэй хүн ажилласан амжилтыг хадгалж, дараагийн даргад эмэгтэй хүн томилох.

II. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хууль, эрх зүйн бодлого, тогтолцоо

Өнөөгийн нөхцөл байдал, ахиц дэвшил

2.1. Эрх зүйн орчин. Монгол Улсын Үндсэн хуульд “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна. Хүнийг хүйс...ээр нь ялгаварлан гадуурхаж үл болно. Улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ.

Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална.” хэмээн жендэрийн эрх тэгш байдлын үндсэн зарчмыг заан тогтоосон.

Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлснээр УИХ 2011 онд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай тусгайлсан хуулийг баталж, улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд жендэрийн эрх тэгш байдлын баталгааг хангах эрх зүйн суурь үндсийг бүрдүүлсэн юм. Мөн Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг батлан, хуулиар төрийн албанд тогтоосон квотыг тодорхой үе шаттай хэрэгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөөг Засгийн газар баталж, 2016 он хүртэл хугацаанд багтаан хэрэгжүүлсэн байхаар заасан.

ЖЭТБХТХ-ийг дагалдуулан 4 хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан. Монгол Улсын Засгийн газрын тухай хууль/1993/ -ийн Засгийн газрын бүрэн эрхэд ...“жендэрийн эрх тэгш байдлыг хангах”, Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд “-жендэрийн хөгжлийн асуудал;” хамаарах нэмэлт оруулсан. Хөдөлмөрийн тухай хууль/1999/ -д Ажил олгогч болон Ажилтан нь “ЖЭТБХТХ-д заасан эрх эдэлж, үүрэг хүлээх” тухай заалт нэмж, хөдөлмөрийн харилцаанд ялгаварлал, хязгаарлал, давуу байдал тогтоохыг хориглох заалтад “эрэгтэй, эмэгтэй” гэж нэмэлт оруулсан бөгөөд 2021 онд шинэчлэн найруулсан. Төрийн албаны тухай хууль/1993/-ийн Төрийн жинхэнэ албан хаагчийн хориглох зүйлд “Иргэнийг ...жендэрийн шууд ба шууд бус хэлбэрээр ялгаварлан гадуурхах.”, Төрийн жинхэнэ албан тушаал эрхлэх болзолд “хүйс”-ээр ялгаварлахгүй байх, “сонгон шалгаруулалт болон мэргэшлийн шалгалтад орж адил оноо авсан боловч хүйсийн шинжээр тэнцээгүй иргэн төрийн албаны төв байгууллагад гомдлоо гаргаж болно.” гэсэн нэмэлт оруулсан, 2017 онд шинэчилсэн. Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын тухай хууль/2000/-д “Комиссын гишүүдээс нэг нь жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих асуудлыг хариуцах”-аар нэмсэн. Уг хуулийг 2020 онд шинэчлэн найруулахдаа Комиссын чиг үүрэгт энэ заалтыг нэмсэн. Хуульд шинээр “Комиссын гишүүнийг томилохдоо жендэрийн тэгш байдлыг харгалзан үзэх бөгөөд гишүүний 40-өөс доошгүй хувь нь аль нэг хүйсийн төлөөлөл байна.” хэмээн зааж, энэ заалтыг хангасан томилгоо хийсэн нь ахиц дэвшил юм.

УИХ 2004 онд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх анхны хуулийг батлан, 2017 онд шинэчилсэн найруулсан. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийг 2012 онд баталсан. Иргэний хууль /2002/, Гэр бүлийн тухай хууль /1999/-иудад гэр бүлийн гишүүдийн өмчийн харилцааг зохицуулахад жендэрийн агуулга тусгагдсан.

Сүүлийн үед УИХ-аас баталсан Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль /2021/, Хууль зүйн туслалцааны тухай хууль /2022/, Шүүхийн шинжилгээний тухай хууль /2023/-иуд болон шинэчлэн найруулж баталсан Хөдөлмөрийн тухай хууль /2021/-д жендэрийн үзэл баримтлал тусгасан ахиц дэвшил гарсан.

Энэ үнэлгээний хүрээнд 2023 онд ПССХ-ээс гаргасан тойм судалгаанд “2011-2020 онд УИХ бие даасан 253 хууль баталсны 140 нь жендэрийн холбогдолгүй, жендэрийн үзэл баримтлал шууд агуулсан жендэрийн холбогдолтой 74 хууль батлагдан гарсан, 70 бодлогын баримт бичгийн 16 буюу 22.9%-д жендэрийн асуудлыг тусгасан.” гэсэн дүгнэлт хийсэн. Үүнийг мэргэжлийн үүднээс дахин шинжлэн үзэх шаардлагатай.

2.2.Хөгжлийн бодлого. Монгол Улс Тогтвортой хөгжлийн зорилго /ТХЗ/-ын жендэрийн буюу 5-р зорилгыг “Алсын хараа-2050” урт хугацааны бодлогод тусгайлан

тусгаагүй, зөвхөн шалгуур үзүүлэлтэд Жендэрийн тэгш бус байдлын индекс хэрэглэснээр хязгаарласан. Мөн Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл /2020/ -д тэгш боломжийн ерөнхий утга бүхий заалт тусгасан. Харин Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр /2020/, Монгол Улсын хөгжлийн 2022, 2023 оны төлөвлөгөөнд жендэрийн агуулгатай арга хэмжээг төлөвлөсөн нь ахиц дэвшил болсон байна.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр, стратегийг 2002, 2013, 2017 онд батлан хэрэгжүүлсний гадна өнөөгийн нөхцөлд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөөг 2022-2031 онд хэрэгжүүлэхээр ЖҮХ-ноос 2022 онд баталсан. Энэ нь НҮБ-ын “ТХЗ-2030” бодлого болон Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенци, Монгол Улсын Үндсэн хууль, ЖЭТБХТХ-ийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн 5 үндсэн зорилгыг дэвшүүлсэн. Үүнд: “1.Охид, хөвгүүд, эмэгтэй эрэгтэй хүмүүст эрүүл, аюулгүй амьдрах, сурч боловсрох тэгш боломж бүрдүүлнэ. 2.Эдийн засгийн хүрээнд жендэрийн тэгш боломж, тэгш оролцоог дэмжинэ. 3.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний тогтолцоог хөгжүүлнэ. 4.Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо, манлайллыг нэмэгдүүлнэ. 5.Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицоход жендэрийн тэгш оролцоог хангана.”

Салбарын болон орон нутгийн жендэрийн эрх тэгш байдлыг хангах дунд, богино хугацааны бодлого стратеги төлөвлөгөөг 2014 оноос эхлэн боловсруулан баталж, өнөөгийн байдлаар 14 салбарын бодлогыг салбарын сайд, орон нутгийн дэд хөтөлбөрийг бүх 21 аймаг, нийслэл, бүх 9 дүүрэгт нутгийн өөрөө удирдах байгууллагын удирдлага батлан хэрэгжүүлж байна. “Жендэрийн мэдрэмжтэй ажлын байрны бодлого (2022-2031)-ыг Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооноос 2022 онд баталсан.

2.3.УИХ-ын өөрийн зохицуулалтын бодлого, хууль тогтоомж. Монгол Улсын Их Хурлын тухай хууль /2020/-д Нийгмийн бодлогын байнгын хороо /НББХ/-нд жендэрийн тэгш байдлыг хангах бодлого хамаарахаар заасан. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль /2020/-д жендэрийн талаарх Засгийн газрын болон ХЭҮК-ийн илтгэлийг НББХ, Хууль зүйн байнгын хороонд, ТАЗ-ийн тайланг Төрийн байгуулалтын байнгын хороонд тус тус хэлэлцүүлэхээр заасан.

УИХ-ын 2019-2024 оны стратеги төлөвлөгөө/2019/-нд Жендэрийн тэгш байдлыг хангаж, эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дэмжих; УИХ дахь эмэгтэй гишүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх механизмыг бүрдүүлж, жендэрийн мэдрэмжтэй парламентыг төлөвшүүлэх зорилтыг дэвшүүлсэн. Тэрчлэн, Бээжингийн тунхаглалын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар “Засгийн газар бүр өөрийн бүх бодлого, хөтөлбөрт жендэрийн үзэл баримтлал тусгах, жендэрийн асуудал нь тухайлан нэг салбарын асуудал бус салбар дундын асуудал тул тогтолцоог тасралтгүй бэхжүүлэх.”; НҮБ-ын Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц /ЭАБХУТК/-ын хорооны 2016 оны зөвлөмжид заасан, “конвенцийг үр дүнтэй хэрэгжүүлэх, үйл ажиллагааны төвлөрлийг сааруулах зарчмаар явуулахад нь хүний нөөцийн, техникийн болон санхүүгийн хөрөнгө нөөцөөр хангах замаар Жендэрийн үндэсний хороог бэхжүүлэх” асуудлуудыг тусгасан.

УИХ-ын Тамгын газрын стратеги төлөвлөгөө/2020-2024/-нд “Улсын төсвийн төсөл, төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөлөл нь ... жендэрийн тэгш байдлыг хангасан, хүний эрхэд суурилсан эсэхэд шинжилгээ хийж, дүгнэлт гаргах, Тамгын

газрын удирдах болон бусад ажилтны дотор жендэрийн тэгш байдлыг хангах, хууль тогтоомжид заасан механизмыг хэрэгжүүлэх;"-ээр тусгасан.

УИХ, ОУПХ хооронд Хамтын ажиллагааны санамж бичгийг хүний эрх, жендэрийн асуудлаар хамтран ажиллах санамж бичгийг 2022 оны 08 дугаар сард байгуулсан ба УИХ-ын бүтэц, үйл ажиллагаанд хүний эрхэд суурилсан, жендэрийн мэдрэмжтэй парламентыг бэхжүүлэх чиглэлд хамтран ажиллахаар тунхагласан.

Нөлөөлж буй хүчин зүйлс, саад бэрхшээл

УИХ өөрийн зохицуулалтын бодлого, хууль тогтоомжийг жендэрийн үзэл баримтлалтай болгох, УИХ-ын гишүүд, ажилтнууд жендэрийн хэвшмэл үзлээс ангид байх, улс орны хэмжээнд батлан гаргаж байгаа хууль тогтоомжийг жендэрийн үүднээс үнэлж, эмэгтэй, эрэгтэйчүүдийн ялгаатай хэрэгцээнд нийцсэн, тулгамдсан асуудлыг шийдвэрлэсэн, бодит нөхцөл байдлыг өөрчилсөн байдлаар жендэрийн агуулгыг тусгасан, чухамхүү үүнд зориулсан хөрөнгө санхүүжилтийг жендэрийн мэдрэмжтэй төсөвлөж хуваарилж байж сая УИХ өөрийн зорилгодоо хүрэх учиртай.

УИХ бодлогын гол хуулиуд болох Хууль тогтоомжийн тухай хууль/2015/, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль/2015/, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль/2020/, Төрийн албаны тухай хууль/2017/-иудыг батлан гаргахдаа жендэрийн үзэл баримтлал тусгаагүй байна.

Хууль тогтоомжийг бүхэлд нь жендэрийн агуулгатай батлан гаргахын тулд нэн тэргүүнд Хууль тогтоомжийн тухай хуульд жендэрийн урьдчилсан үнэлгээ хийх асуудлыг тухайлан тусгаж, хэрэгжилтийг хангуулах нь тулгамдсан асуудал болж байна.

Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд жендэрийн үзэл баримтлал тусгаагүй явдал нь Монгол Улсын хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлогод бүхэлд нь жендэрийн үзэл баримтлал нэвтрүүлэх бодлого, эрх зүйн орчин бүрдүүлэхэд сөргөөр нөлөөлж байна.

Тэрчлэн Төрийн албаны тухай хуулийг жендэрийн агуулгатай болгон шинэчлэхгүйгээр тус улсын жендэрийн нөхцөл байдлыг өөрчлөн, ахиц дэвшил гаргахад ихээхэн хүндрэлтэй гэдэг нь тодорхой юм.

ЖЭТБХТХ-иар, Засгийн газрын бүрэлдэхүүн, яам, агентлаг, бусад төв байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн удирдлагад тогтоосон хүйсийн квотыг бүрэн хангах, өөрөөр хэлбэл хуулиар тогтоосон заалтаа УИХ, Засгийн газар, эрх бүхий удирдах албан тушаалтан зөрчсөөр байгааг зогсоох нь ихээхэн тулгамдсан асуудал болж байна. Үүнд, тухайн асуудлын ач холбогдлыг ойлгож хэрэгжүүлэх эрх бүхий этгээдийн мэдлэг туршлага, хүсэл зориг, жендэрийн хэвшмэл үзлээ даван туулах хандлагын өөрчлөлт хийх чадвар зэрэг хувь удирдах албан тушаалтны хамаарал голлох нөлөөтэй гэдэг нь тодорхой юм.

Монгол Улсын Их Хурлын тухай хууль/2020/-д НББХ-нд жендэрийн тэгш байдлыг хангах бодлого хамаарахаар зааснаас өөр жендэрийн асуудлаар зохицуулалт байхгүй. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль/2021/, Нийтийн сонголын тухай хууль/2015/, Монгол Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрэм /2021/-д жендэрийн асуудлыг тусгаагүй. Тамгын газраас баталсан төсвийн төсөл жендэрийн мэдрэмжтэй боловсрогдсон эсэхийг шинжлэх аргачлал, шалгуур

үзүүлэлтийн дагууд тухайн жилийн Төсвийн тухай хуулийн төсөлд жендэрийн дүн шинжилгээ хийгээгүй байна.

Хууль тогтоомжийн хүний эрхийн үнэлгээний хүрээнд жендэрийн үнэлгээ хийх аргачлалыг Засгийн газар батлан гаргасан боловч бодит байдал дээр энэ үнэлгээ үндсэндээ хийгдэхгүй байна. ЖҮХ-ны Ажлын алба, Үндэсний шинжээчид хамтран “Хууль тогтоомжийн жендэрийн үнэлгээ” аргачлалыг 2019 онд боловсруулж, Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалд тус тус нэмэлт оруулах саналаа УИХ-ын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн боловч одоогоор үр дүн гараагүй байна.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар УИХ-д тусгайлсан бодлого стратеги байхгүй, өөрийн зохицуулалтын хууль журамд жендэрийн үзэл баримтлал нэвтрүүлээгүй байгаа нь үндэсний хэмжээний бодлого хуулийг боловсруулах шатанд жендэрийн урьдчилсан үнэлгээ хийх, түүнд үндэслэн тэдгээрийг жендэрийн үзэл баримтлалтай батлах асуудал үндсэндээ орхигдоход хүргэж байна. Тэрчлэн улсын хөгжлийн урт хугацааны бодлогод ТХЗ-ын жендэрийн зорилгыг тусгаагүй, Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн хэрэгжилтэд УИХ ямар нэг оролцоогүй байгаа зэрэг нь олон улсын өмнө болон Үндсэн хууль, ЖЭТБХТХ-д заасан хууль тогтоомж, хөгжлийн бодлогыг жендэрийн эрх тэгш байдлыг хангасан байхаар тодорхойлох, эрэгтэй, эмэгтэй хүний эрх тэгш баталгааг хангах эрх зүйн орчныг бүрдүүлэх талаар хүлээсэн үүргээ УИХ биелүүлэхэд саад тотгор болж байна.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах эрх зүйн бодлого, тогтолцоог боловсронгуй болгохын тулд хийж хэрэгжүүлэх зүйлс:

1. УИХ хүн амын хүйсийн болон бусад төлөөллийг бүрэн хангахуйцаар өөрийгөө бүрдүүлэх, бодлого, үйл ажиллагаандаа жендэрийн эрх тэгш байдлыг хангах тусгайлсан стратеги төлөвлөгөө баталж хэрэгжүүлэх, шаардагдах хүний болон санхүүгийн нөөцөөр хангах.
2. УИХ-аас үндэсний хэмжээнд жендэрийн эрх тэгш байдлыг хангах бүрэн эрхээ хэрэгжүүлэх механизмыг тогтоож, дунд хугацааны стратеги төлөвлөгөө боловсруулан, жендэрийн өөрийн үнэлгээний зөвлөмжийг тусган баталж хэрэгжүүлэх.
3. НҮБ-ын ТХЗ-2030 бодлогын 5 дугаар зорилго буюу жендэрийн эрх тэгш байдлыг хангах зорилгыг урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогод тусгайлан тусгаж оруулах, хэрэгжилтийн шалгуур үзүүлэлтэд жендэрийн шаардагдах үзүүлэлтийг нэмэх.
4. ТХЗ-ын хэрэгжилтийн явцыг зохих ёсоор тайлагнаж, хянаж, үнэлэхэд ахиц гаргахын тулд Монгол Улсын ТХЗ-ын үндэсний шалгуур үзүүлэлт, тэдгээрийн зорилтот түвшнийг албан ёсоор баталгаажуулах.
5. ТХЗ-ын болон Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн хэрэгжилт, илтгэл тайланг хэлэлцэх асуудлыг УИХ-ын тухай хууль тогтоомжид тусгах.
6. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд жендэрийн үзэл баримтлал тусган шинэчлэх, бодлого боловсруулах, хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ, тайлагналтад хүйсээр ангилсан шалгуур үзүүлэлт тусгахаар зохицуулах.
7. Хууль тогтоомжийг жендэрийн агуулгатай боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт үнэлгээ хийх зарчимд шилжих, үүний тулд нэн тэргүүнд хууль тогтоомжид жендэрийн нөлөөллийн үнэлгээ хийх зохицуулалт, аргачлалыг Хууль тогтоомжийн тухай хуульд тусган мөрдүүлэх.

8. Нийтийн сонсголын төрөлд болон хууль тогтоомжийн төсөл боловсруулах сонсголд жендэрийн эрх тэгш байдлын асуудлыг оруулах, сонсголын явцад жендэрийн ялгаварлан гадуурхалтыг хориглох, сонсгол даргалагч, оролцогчдын хүйсийн байдлыг харгалзах тухай нэмэлт зохицуулалт хийх.
9. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд хяналт шалгалтын зорилго, зарчимд болон хяналтын сонсголын төрөлд жендэрийн эрх тэгш байдлыг хангах асуудлыг нэмж тусгах.
10. Төрийн албаны тухай хууль тогтоомжийг жендэрийн үзэл баримтлалтай болгон шинэчилж, төрийн байгууллага, албан тушаалтан жендэрийн ялгаварлан гадуурхалт, дарамт хүчирхийллийг арилгахад манлайлах үүрэг гүйцэтгэх, шаардлагатай ажлын байрыг хүйс зааж зарлах, цөөн тоотой хүйсийн хүнийг ажилд сонгон авах боломж бүхий журмыг хуульчлах, хэрэгцээт мэргэжлээр эмэгтэй, эрэгтэй мэргэжилтнийг төлөвлөлт захиалгын үндсэн дээр бэлтгэх тусгай арга хэмжээ авч хэрэгжүүлэх.
11. Улс төр, эдийн засаг, хөдөлмөр, соёл, боловсрол, эрүүл мэнд болон гэр бүлийн харилцааг зохицуулдаг тусгайлсан хууль тогтоомжид жендэрийн эрх тэгш байдлыг хангах баталгааг нарийвчлан тусгаж, жендэрийн агуулгатай болгон шинэчлэх.
12. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг тодорхой тогтоож, Төрийн албаны тухай хууль, Зөрчлийн, Эрүүгийн зэрэг холбогдох хуульд нэмэлт өөрчлөлт оруулах.
13. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд заасан, төрийн албанд тогтоосон хүйсийн төлөөллийн доод хэмжээг 2024 онд багтаан биелүүлж, цаашид бүх түвшинд хүйсийн тэнцвэр хангах бодлого төлөвлөлтийг УИХ, Засгийн газар тусгайлан гаргах.
14. Хөдөлмөрийн үнэлэмжийг зохистой тогтоож, үндэсний жижиг дунд ногоон үйлдвэрлэлийг дэмжиж, “эмэгтэйчүүдийн аж ахуй эрхлэлт”-ийн тодорхойлолтыг хуулиар тогтоож, санхүүгийн зохих хөшүүргээр дэмжих тусгай арга хэмжээ авах.
15. Эрэгтэй, эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн оролцоо, цалин хөлс, амьдралын чанарт жигд ахиц дэвшил гаргахын тулд тэдний онцлог хэрэгцээнд нийцсэн хөдөлмөр эрхлэлтийн онцлог ялгамжтай бодлогыг хүйсээр ангилсан мэдээлэл, жендэрийн дүн шинжилгээнд үндэслэн шинэчлэн зохион байгуулах.
16. Баялгийн хуваарилалтыг шударга, ил тод, жендэрийн агуулгатай болгох.
17. Эмэгтэйчүүдэд бараг бүхэлдээ ногдож байгаа гэрийн ажил, хүүхэд, гэр бүлийн гишүүдээ асрах асар их хөлсгүй хөдөлмөрийг эрэгтэйчүүд хуваалцах, түүнийг нийгмийн баялаг бүтээх, өрхийн эдийн засагт оруулсан хувь нэмэр хэмээн тооцож, үндэсний тооцооны системд нэвтрүүлэх зорилтыг бодитоор хэрэгжүүлэх.
18. Хүмүүст хортой, амьд бүхэнд хохиролтой, ёс зүйгүй бизнесээс татгалзаж, хүнд болон амьтанд ээлтэй, ёс зүйтэй бизнесийг хөрөнгө оруулалт, санхүүгийн урамшуулал хөшүүргээр дэмжих.
19. Ногоон хөгжлийн болон жендэрийн бодлогыг бүх бодлогын суурь болгон тогтоож, ялангуяа эдийн засгийн, дэд бүтцийн, уул уурхайн бодлогыг ногоон бодлогод үндэслэн шинэчилж, байгаль орчны болон жендэрийн үзүүлэлтийг тэдгээрт үндсэн шалгуур үзүүлэлт болгох.
20. Хүн амын оршин амьдрах анхдагч орчин болсон газар нутаг, ус, ургамал, агаарын зохист нөхцлийг хөндөхгүй байх, бий болж болзошгүй өөрчлөлтийг жендэрийн үнэлгээгээр тооцож, бүх бодлого, төсөл хөтөлбөр, үйл ажиллагааны үндсэн шалгуур болгон хэрэглэх.
21. Сэргээгдэх эрчим хүчний бодлогод жижиг дунд үйлдвэрлэл, айл өрх, ААНБ, хот суурины гэр хороолол, сум сууринд жижиг нар, салхины станцаар хэрэглээгээ

хангах, түүнээс нийтийн сүлжээнд нийлүүлж орлогоо нэмэгдүүлэх тусгайлсан арга хэмжээг жендэрийн мэдрэмжтэй төлөвлөж, хэрэгжүүлэх.

III. Парламентад жендэрийн үзэл баримтлал нэвтрүүлэх нь

Өнөөгийн нөхцөл байдал, ахиц дэвшил

3.1. УИХ-ын бүтцийн механизм. УИХ-д жендэрийн эрх тэгш байдлыг хангах албан ёсны бүтэц нь Тогтвортой хөгжлийн зорилтын дэд хороо уг асуудлыг хариуцан, жендэрийн асуудлаар нэг зөвлөх, нэг референт ажиллаж байна. Хууль тогтоомжид заагдаагүй албан бус бүтцүүд болох УИХ-ын нийт 13 эмэгтэй гишүүнээс бүрдсэн “Улсын Их Хурал дахь эмэгтэй гишүүдийн бүлгэм”, УИХ-ын даргын дэргэдэх “Эмэгтэй парламентчдын орон тооны бус зөвлөл”, “Шийдвэр гаргах түвшинд жендэрийн эрх тэгш байдлыг дэмжих Лобби бүлэг”, ЖҮХ-ны дэргэд УИХ-ын эмэгтэй гишүүд, эмэгтэй сайд нараар бүрдсэн “Бодлогын зөвлөл”-ажиллаж байна. ЖҮХ, Бодлогын зөвлөл, Лобби бүлгийн хамтын санаачилга, манлайлал УИХ-ын сонгуульд нэр дэвшигчийн хүйсийн квотыг нэмэгдүүлэх, Улс төрийн намын тухай хуульд жендэрийн агуулга тусгахад үр дүнгээ өгчээ. Тогтвортой хөгжлийн олон талт зөвлөл⁵ нь Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийг эрчимжүүлэхэд Засгийн газарт дэмжлэг үзүүлэх, мөн Тогтвортой Хөгжлийн Үндэсний Зөвлөлийг бэхжүүлэх зорилгоор ажиллаж байна.

УИХ-ын бүтцэд ПССХ ажиллаж, нотолгоонд суурилсан судалгааны баримт мэдээлэл, лавлагаагаар хангах, мэдээллийн сан бүрдүүлэх, УИХ, Тамгын газрын чадавхыг бэхжүүлэх болон олон нийтэд парламентын боловсрол олгох сургалтын чиглэлээр ажилладаг.

3.2. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний тогтолцоо, байгууллагуудын уялдаа холбоо. ЖЭТБХТХ-д зааснаар Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх ажлын хүрээнд жендэрийн эрх тэгш байдлыг хангах асуудал хамаарах бөгөөд Тэрээр ЖҮХ-г тэргүүлж, удирдлагаар хангаж ажилладаг. Үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэгч ЖҮХ нь жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлогыг хэрэгжүүлэхэд төр, олон нийтийн тэнцүү оролцоог хангаж, тогтвортой ажиллах баталгааг бүрдүүлсэн орон тооны бус байгууллага ба ажлын албатай. ЖҮХ нь СЕХ, ҮСХ, ХЭҮК, ТАЗ-ийн удирдлага, 8 яамны Төрийн нарийн бичгийн дарга, бусад 6 төрийн байгууллагын төлөөлөл, Үндэсний олон нийтийн радио, телевиз, 15 ТББ, нийт 27 гишүүний бүрэлдэхүүнтэй байна. Мөн бүх яам, ЗГ-ын агентлаг, нийслэл, бүх дүүрэг, бүх аймагт болон зарим суманд жендэрийн салбар зөвлөл, хороо ажиллаж байна. ЖҮХ-ны дэргэд Жендэрийн үндэсний шинжээчдийн бүлэг, Жендэрийн эрдэмтэн судлаачдын бүлэг, Хэвлэл мэдээллийн зөвлөл ажиллаж, Ажлын алба 14 орон тоотой үйл ажиллагаа явуулж байна. ЖЭТБХТХ-д зааснаар Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнгийн талаархи Засгийн газрын тайланг 2 жил тутам хэлэлцэж, дүгнэлт гаргах ёстой. Гэвч энэ тайланг тавьж байгаагүй. Харин УИХ-ын НББХ-ны хуралдаан /2021/-д ЖЭТБХТ Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, танилцуулгыг хийж, Байнгын хорооноос Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнг сайжруулах 5 заалт бүхий зөвлөмж өгчээ. Мөн ТББХ /2022/-нд “ЖЭТБХТХ-ийн хэрэгжилт, ач холбогдол, цаашдын үр нөлөө” бага хурал зохион байгуулан, 3 заалт бүхий чиглэлийг өгсөн байна.

⁵ <https://www.parliament.mn/nn/16430/>

ЖЭТБХТХ-д зааснаар жендэрийн чиглэлээр үүрэг хүлээгч бусад гол байгууллагууд нь УИХ-аас байгуулагддаг, хариуцан тайлагнадаг ТАЗ, ХЭҮК, ҮСХ, СЕХ бөгөөд ТАЗ, ХЭҮК, НҮБ-ын ЭАБХУТК-ийн хэрэгжилтийн тайлан, илтгэлийг 2 жил тутам хэлэлцэж, дүгнэлт гаргаж, энэ явцад тэдгээрийн уялдаа холбоог хангах учиртай.

ХЭҮК нь “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хууль тогтоомжийн хэрэгжилтийн төлөв байдал, жендэрийн ялгаварлан гадуурхалттай холбоотой гомдлын хянан шийдвэрлэлтийн талаархи илтгэл”-ийг тусгайлан танилцуулж байгаагүй. Харин Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 13, 16, 17, 18, 21, 22 дахь илтгэлдээ ажлын байрны бэлгийн дарамт, улс төрийн хүрээ, бусад хүрээн дэх жендэрийн эрх тэгш байдлын талаар танилцуулж, тодорхой асуудлаар шийдвэрт тусгах саналыг дэвшүүлж, нэлээд хүчин чармайлт гарган ажиллаж ирсэн.

ТАЗ жендэрийн асуудлаарх тусгайлсан тайланг УИХ-аар хэлэлцүүлж байгаагүй байна. Харин 2019 оноос суурь судалгаа хийлгэж, зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр ажиллаж, 2020 оноос эхлэн Төрийн албанд жендэрийн тэгш байдлыг хангах 2021 оноос 2023 хүртэлх үйл ажиллагааны төлөвлөгөө гарган, Төрийн албаны шинэтгэлийн алсын хараандаа “жендэрийн мэдрэмжтэй соёлыг төлөвшүүлэх”, “Жендэрийн хууль тогтоомжийг төрийн албанд хэрэгжүүлж, жендэрийн мэдрэмжтэй төрийн албыг төлөвшүүлэхэд ахиц дэвшил гаргах”-аар зорьж ажиллан, Төрийн албан хаагчийн сонгон шалгаруулалтад жендэрийн асуудал тусган ихээхэн ахиц дэвшилтэй ажиллаж байна.

УИХ-аас 2021 онд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулснаар Засгийн газрын болон ТАЗ-ын тайлан, ХЭҮК-ийн илтгэлийг байнгын хороодоор хэлэлцэхээр, холбогдох хууль тогтоомжийн төсөл боловсруулж, нэгдсэн хуралдаанд танилцуулж болох тухай заасан юм.

УИХ-аас Монгол Улсын статистикийн салбарыг 2011-2015 онд, 2017-2020 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг батлан гаргаж, Үндэсний Статистикийн Хороо/ҮСХ/-ноос 2019 онд Жендэрийн статистик үзүүлэлтийн хамрах хүрээ, аргачлалыг шинэчлэн баталж, нийт 14 бүлгийн 241 үзүүлэлтийг хамруулж, албан ёсны статистикийн мэдээлэл буюу статистикийн мэдээ, судалгаа, тооллогын мэдээллийг хүйсээр ангилж цуглуулах, дүн шинжилгээ хийх, тархаах чиглэлд ихээхэн ахицтай ажиллаж байна.

3.3. Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт. УИХ хууль тогтоомж, олон улсын гэрээ, төрийн бодлогын хэрэгжилтийг хангахуйц хөрөнгө батлах; Засгийн газар жендэрийн мэдрэмжтэй төсвийн төлөвлөлтийн тогтолцоог нэвтрүүлэх асуудлыг хэрэгжүүлэхээр ЖЭТБХТХ-д заасан. 2011-2019 оны байдлаар авч үзэхэд жендэрийн асуудлаар зарцуулсан хөрөнгийн 3.6%-ийг улсын төсвөөс, 96.4%-ийг Хөгжлийн албан ёсны түншлэгчдээс олгожээ⁶. Харин 2020 оноос хойш улс, орон нутгийн төсвийн хэмжээнд зарим ахиц гарсан байна.

Засгийн газрын Тогтвортой хөгжлийн үндэсний хорооноос баталсан Үндэсний санхүүжилтийн нэгдсэн стратеги/2022/-д ЖДҮ-ийн 60%-иас доошгүйг эмэгтэйчүүд эзэмшдэг боловч тэдгээрийн 70% нь санхүүжилт огт авдаггүй эсвэл хангалтгүй авдаг, эмэгтэйчүүдийн ажил эрхлэлтийн түвшин 52%, дээд шатны удирдлагын зөвхөн 29% нь эмэгтэйчүүд байгаа тул хүртээмжтэй, тогтвортой өсөлтийг бий болгохын тулд тэгш оролцоог хангах шаардлагатайг онцолжээ. Түүнчлэн хувийн хэвшлийн санхүүжилтэд жендэрийн мэдрэмжтэй, үр дүнд суурилсан төсөвлөлт нэвтрүүлэх, жендэрийн тэгш

⁶ ЖЭТБХТХ-ийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, 2020

байдлыг хангах зэргээр макро эдийн засгийн орчинг бүрдүүлэх асуудлыг тусгаж баталгаажуулсан нь ихээхэн дэвшилт болсон юм.

Нөлөөлж буй хүчин зүйлс, саад бэрхшээл

УИХ-д хууль, бодлого боловсруулах, төсөвлөх, хэлэлцэх, батлах, хэрэгжүүлэх, хяналт үнэлгээ хийх үйл явц, үе шатанд жендэрийн агуулга, аргачлал нэвтрээгүй байна. УИХ-д жендэрийн эрх тэгш жендэрийн үзэл баримтлал нэвтрүүлэх тусгайлсан бодлого байхгүй, Тогтвортой хөгжлийн зорилтын дэд хороонд нэг зөвлөх, нэг референт жендэрийн асуудлыг хариуцан ажиллаж байгаагаас өөр албан ёсны бүтэц байхгүй нь жендэрийн талаар УИХ хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхэд гол саад бэрхшээл болж байна. Одоо ажиллаж буй албан бус бүтцүүд болох эмэгтэйчүүдийн бүлгүүд болон шийдвэр гаргах түвшинд жендэрийн эрх тэгш байдлыг дэмжих лобби бүлэг зэрэг нь хууль тогтоомжид заагдаагүй албан бус статустай учир хүний болон санхүүгийн нөөцөөр хангагдаагүй, тэдний дүгнэлт санал зөвлөмжийг УИХ-ын хууль, бодлого, үйл ажиллагаанд тусгах хуульчилсан зохицуулалтгүй байгаа нь үр дүн, үр нөлөөг нь бууруулж байна.

ПССХ-ийн үйл ажиллагаанд хүйсээр ангилсан мэдээлэл, жендэрийн дүн шинжилгээний аргачлал нэвтрээгүй байна. УИХ-ын Тамгын газар, эрх зүйн болон төсвийн дүн шинжилгээний хэлтсээс хууль тогтоомж, түүний төсөлд жендэрийн үнэлгээ хийх эрх хэмжээ болон аргачлалын талаар хууль тогтоомжид тусгаагүй байгаа нь хууль, бодлого, үйл ажиллагаа, хяналт үнэлгээнд жендэрийн үзэл баримтлал нэвтрүүлэхэд тавих хяналтыг хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлж байна.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнгийн талаархи Засгийн газрын тайлан болон жендэрийн чиглэлээр үүрэг хүлээгч байгууллагууд болох УИХ-аас байгуулагдаж, тайлагнадаг ТАЗ, ХЭҮК-ийн тайлан, илтгэлийг 2 жил тутам хэлэлцэж, дүгнэлт гаргах үүргээ УИХ өнөө хүртэл биелүүлээгүй байна. Энэ нь УИХ дээрх байгууллагуудын үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт, заавар чиглэл өгөх замаар хоорондын хамтын ажиллагааг уялдуулах боломжийг хэрэгжүүлэхгүйд хүрч байна.

Мөн УИХ НҮБ-ын “Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенци”-ийн хэрэгжилтийн талаарх Монгол Улсын ээлжит тайланг УИХ-д хэлэлцэж байгаагүй байна.

Энэчлэн УИХ баталсан хуулийн дээрх заалтуудыг өөрөө хэрэгжүүлээгүй явж ирсэн нь бодлого төлөвлөлт, төсөвлөлт, хяналт үнэлгээндээ жендэрийн үзэл баримтлал нэвтрүүлэхэд ахиц дэвшил гарахгүй байх үндсэн хүчин зүйл болж байна.

УИХ-д жендэрийн үзэл баримтлал нэвтрүүлэхэд хийж хэрэгжүүлэх зүйлс:

1. УИХ, хууль, бодлого, үйл ажиллагааг төлөвлөх, төсөвлөх, хэлэлцэх, батлах, хэрэгжүүлэх, хяналт үнэлгээ хийх бүх шатанд жендэрийн агуулга, аргачлал нэвтрүүлэх тусгайлсан бодлого баталж хэрэгжүүлэх.
2. Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт (ЖМТ)-ийн тогтолцоог бүх шатны байгууллагуудад нэвтрүүлэх талаарх Сангийн яамны хүчин чармайлтыг бататган, Үндэсний санхүүжилтийн нэгдсэн стратегийг хэрэгжүүлэх, төсөвт жендэрийн дүн шинжилгээ хийх аргачлалыг баталж, УИХ-аас Төсвийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид шинэчлэл хийх.
3. УИХ-д жендэрийн бүлэг байгуулах, Жендэрийн тусгайлсан хороо байгуулах, одоо ажиллаж байгаа эмэгтэйчүүдийн бүлгийг албан болгох болон жендэрийн бусад механизмын талаар зохицуулалт хийх.

4. Жендэрийн эдгээр албан ёсны бүтцийг хүний болон санхүүгийн нөөцөөр хангаж, жендэрийн шинжээчдийг бэлтгэж, жендэрийн үнэлгээ дүгнэлт хийдэг, түүнийг УИХ-ын хууль, бодлого, шийдвэрт тусгадаг эрх зүйн орчныг бүрдүүлэх.
5. Хууль тогтоомж, түүний төсөлд жендэрийн нөлөөллийн үнэлгээ хийх аргачлалыг хуульчлан баталж, жендэрийн урьдчилсан үнэлгээ хийгээгүй нөхцөлд Тамгын газар, эрх зүйн хэлтсийн дүгнэлтээр хууль санаачлагчид буцаах зохицуулалт бий болгох.
6. Жендэрийн нөлөөллийн үнэлгээний аргачлалд тулгуурлан, бүх хууль тогтоомжид жендэрийн үнэлгээ хийж, жендэрийн агуулга тусгах жагсаалт гарган хэрэгжүүлэх.
7. ЖЭТБХТХ-ийн 15, 19 дүгээр зүйлд заасан жендэрийн үнэлгээний хэрэгжилтийг Засгийн газраас шаардаж хангуулдаг байх.
8. ПССХ-ийн үйл ажиллагаанд хүйсээр ангилсан мэдээлэл, жендэрийн дүн шинжилгээний аргачлал нэвтрүүлж, нотолгоонд суурилсан жендэрийн статистикийн тоон болон чанарын мэдээллийг боловсруулж, хэрэглэж, олон нийтэд хүргэх тогтолцоог хэвшүүлэх.
9. УИХ-д ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын эрх бүхий албан тушаалтныг томилоход хүйсийн тэнцвэрт байдлыг хангаж, жендэрийн хууль тогтоомжид заасан квотыг хэрэгжүүлэх.
10. ЖЭТБХТХ-д заасан, Засгийн газрын бүрэлдэхүүн, яам, агентлаг, бусад төв байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн удирдлагад тогтоосон хүйсийн квотыг бүрэн хангахад хяналт тавьж, цаашид эдгээр квотыг нэмэгдүүлэн тогтоох.
11. Төрийн албан дахь жендэрийн эрх тэгш байдлыг хангах тогтолцоо, хүйсээр ангилсан мэдээллийг сайжруулах, удирдах албан тушаалын хүйсийн харьцааг хууль тогтоомжид заасан шаардлагад нийцүүлэх ажлыг эрчимжүүлэхэд ТАЗ-д эрх зүйн дэмжлэг болон хөрөнгө нөөцөөр хангах.
12. ХЭҮК-ийн жендэрийн чиглэлээрх илтгэл, тайлан, санал зөвлөмжийг шийдвэрт тусган хэрэгжүүлэхэд анхаарах.
13. ЖҮХ, ХЭҮК, ТАЗ, ҮСХ зэрэг байгууллагуудын жендэрийн үнэлгээ дүгнэлтийг УИХ-ын үйл ажиллагааны бүх үе шатанд сонсдог, хууль, бодлогод тусгадаг зохицуулалтыг хуульчлах.
14. Жендэрийн чиглэлээр үүрэг хүлээсэн байгууллагуудын хамтын ажиллагаа, уялдаа холбоог нарийвчлан зохицуулж, хүний болон санхүүгийн нөөцөөр хангах үүргээ бүрэн хэрэгжүүлэх.
15. Парламентад иргэний нийгмийн оролцоо, хяналтыг бий болгоход анхааран, жендэрийн нөлөөллийн, түүний дотор төсвийн хөндлөнгийн үнэлгээг иргэний нийгмийн байгууллагаар хийлгэх, УИХ шийдвэртээ тусгадаг зохицуулалтыг хуульчлах.

IV. Парламент дахь жендэрийн мэдрэмжтэй соёл, орчин, бодлого

Өнөөгийн нөхцөл байдал, ахиц дэвшил

4.1. УИХ дахь жендэрийн эрх тэгш байдлын талаарх ойлголт, хандлага. Өмнөх хэсгүүдэд бичигдсэн ахиц дэвшил болон саад бэрхшээлийн асуудал нь бүхэлдээ тухайн үеийн УИХ-ын гишүүдийн жендэрийн эрх тэгш байдлыг хүлээн зөвшөөрөх, дэмжих эсэх, жендэрийн ойлголт хандлага, жендэрийн хэвшмэл үзлийн илэрхийллийн түвшин юм. Өнөөг хүртэл УИХ Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тусгайлсан хуулийг баталж, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулиудыг батлан, УИХ-ын сонгуульд нэр дэвшигчийн хүйсийн төлөөллийн доод хязгаар 20%-ийн квотыг тогтоон хэрэгжүүлж, улс төрийн намын удирдах байгууллагад

хүйсийн 25%-ийн квотыг тогтоосон зэрэг нь нааштай хандлагыг илэрхийлж байна. Энэ удаагийн УИХ Хөдөлмөрийн тухай зэрэг зарим хууль тогтоомжийг жендэрийн агуулгатай баталж гаргасан, ХЭҮК-ийн гишүүдэд хүйсийн 40%-ийн квот тогтоож, нээлттэй сонгон шалгаруулалтаар квотыг ханган томилгоо хийсэн, УИХ-ын 2024 оны сонгуульд 30%, 2028 оны сонгуульд 40%-иас доошгүйн хүйсийн квотын дагууд нэр дэвшүүлэхээр болсон, улс төрийн намын удирдах байгууллагад хүйсийн квотыг 40%-иас доошгүй болгон нэмэгдүүлсэн, улс төрийн нам, түүний санхүүжилт, сонгуулийн зардлыг бууруулах зохицуулалтад ахиц дэвшил гаргасан, УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд жендэрийн тайлан, илтгэлүүд хэлэлцэх заалт оруулж, УИХ-ын болон Тамгын газрын стратеги төлөвлөгөөнд жендэрийн зарим зорилт дэвшүүлсэн, ОУПХ-той хамтран энэхүү жендэрийн өөрийн үнэлгээ хийж байгаа зэрэг нь УИХ-ын болон Тамгын газрын удирдлага, гишүүдийн жендэрийн хандлагад дэвшил гарсныг харуулж байна.

УИХ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын захирамжаар УИХ-ын гишүүнд болон УИХ-ын Тамгын газрын ажилтанд жендэрийн сургалтын дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж, сургалтууд зохион байгуулж байна. Мөн Тамгын газраас тухайн жилийн Төсвийн тухай хуулийн төсөлд дүн шинжилгээ хийх аргачлал баталж, төсвийн төсөл жендэрийн мэдрэмжтэй боловсрогдсон эсэхийг шинжлэх шалгуур үзүүлэлтүүд тусгасан нь чухал ахиц дэвшил болсон. Сүүлийн жилүүдэд УИХ-аас зохион байгуулж буй арга хэмжээнд оролцогчдын хүйсийн тэнцвэрийг хангахыг эрмэлзэж, бүртгэлийг хүйсээр ангилан гаргаж байна.

УИХ-ын Тамгын газар “ажлын байранд болон байгууллагаас зохион байгуулж буй хамт олны нэгдсэн арга хэмжээнд жендэрийн ялгаварлан гадуурхалт бүхий үг хэллэг, үйлдэл гаргаж, сэтгэл санааны дарамт учруулсан албан хаагчид хариуцлага тооцох.” тухай зохицуулалт хийжээ.

4.2. УИХ, түүний Тамгын газрын ажилтны ажлын орчин нөхцөл. УИХ-ын гишүүдийн ажил, амралтын цагийг тусгайлан зохицуулаагүй, ээлжит чуулганы хугацаа, 7 хоног тутмын намын бүлгийн, ажлын хэсгийн, байнгын, дэд, түр хороодын, чуулганы нэгдсэн хуралдааны хуваарийн дагууд явагддаг. Тухайн ээлжит чуулганы хугацаанд болон чуулганы бус цагт тойрогт, гадаад, дотоодод томилолтоор ажиллах, хувийн ажлаар явах зэрэгт журмын дагуу зохицуулдаг. Эдгээр хууль тогтоомж, дүрэм журам бүхэлдээ эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн ялгаатай хэрэгцээг тооцон үзсэн зохицуулалт байхгүй. 1992 оноос хойшхи парламентын түүхэнд УИХ-ын гишүүн байхдаа амаржсан гишүүн байсан. УИХ-ын гишүүн хүүхэд асрах, жирэмсний, амаржсаны амралттай байх үед УИХ-ын үйл ажиллагаанд хэрхэн оролцох талаар ямар нэгэн зохицуулалт байхгүй. УИХ-ын хууль тогтоомжийн зохицуулалт гэр бүлд ээлтэй эсэх талаар ямар нэгэн үнэлгээ хийгдээгүй.

Төрийн ордонд одоогоор нийт 7 байгууллага байрлан 1500 гаруй хүн ажиллаж, өрөө тасалгааны багтаамж, зай талбайн хувьд хүртээмжгүй, зарим ажилтан өрөөнд хэт олуулаа сууж байна. Үүнээс үүдэн өрөөний хуваарилалтыг жендэрийн хувьд зохистой байдлаар хийх боломжгүй гэсэн тайлбартай байна. Эмэгтэй, эрэгтэй үсчин, бялдаржуулах танхим, зоогийн газар зэргээр үйлчилдэг. Хүүхэд хөхүүлэх, хүүхэд саатуулах, гэр бүлийн өрөө зэрэг үйлчилгээ байдаггүй. УИХ-ын удирдлага, гишүүд, Тамгын газрын удирдлага, ажилтны албан өрөөний хуваарилалт, тохижилт, тоног төхөөрөмжийг албан тушаалын зэрэглэлээр тогтоодог. Төрийн ордонд хүүхэд нэвтрүүлэх, хувцаслалтад тавих шаардлагыг хөнгөрүүлэх зэрэг өөрчлөлт хийгдэж, Төрийн ордон, УИХ-ын чуулганы үйл ажиллагаатай танилцах иргэд, залуусын тоо нэмэгдэж, УИХ-ыг олон нийтэд нээлттэй болгох чиглэлд өөрчлөлт гарч байна.

УИХ-ын нэгдсэн чуулган, хороод, ажлын хэсгийн хуралдааныг цаг сунгаж хуралдуулах үед тэдгээрт оролцогч УИХ-ын гишүүд болон Тамгын газрын ажилтнууд ердийн ажлын өдрийн цагаас илүү ажиллах, ажилтнууд яаралтай үүрэг даалгавар биелүүлэх зэрэгт оройн цагаар, амралт, баяр ёслолын өдрүүдээр ажиллах зэрэг тохиолдлууд нэлээд гардаг. Төрийн захиргааны албан хаагчдыг нормчлоогүй ажлын цагтай гэж үзэж, Тамгын газрын ажилтнууд гарын хээгээр ажлын цагаа бүртүүлж, түүнд үндэслэн цалин хөлсийг тооцон олгох журам үйлчилж байна. Ажилтнууд илүү цагаар, амралт баяр ёслолын үед ажилласан нөхцөлд тодорхой бүртгэлийн дагууд илүү цагийн хөлсийг тооцон олгодог журамтай байгаа ч энэ нь бүрэн хэмжээнд хэрэгждэггүй гэж зарим ажилтан үзэж байна. УИХ-ын зарим гишүүн төв, орон нутгийн байгууллагад богино хугацаанд яаралтай хийж хэрэгжүүлэх үүрэг даалгавар өгдөг нь ажлын ердийн хэмнэлд бэрхшээл учруулж, илүү цагаар, амралтын өдрүүдэд ажиллахад хүргэдэг байна. Бага насны, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилтны нөхцөл байдлыг анхааран үздэггүй, Хөдөлмөрийн тухай хуульд заасан уян хатан зохицуулалт хийдэггүй гэсэн санал шүүмжлэл гарч байв. Зарим ажилтан ирж ажлын цагаа бүртгүүлээд, дараа нь цэцэрлэг, сургуулийн хүүхдээ хүргэдэг зэрэг нь хүндрэлтэй байдаг байна.

УИХ-ын Тамгын газар Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг 2020 онд баталсан байна.

Нөлөөлж буй хүчин зүйлс, саад бэрхшээл

Зарим ахиц дэвшил байгаа хэдий ч УИХ-ын удирдлага, байнгын болон бусад хороод, бүтцийн бусад байгууллагын удирдлагад эмэгтэй гишүүдийг сонгох асуудалд ахиц гараагүй, эмэгтэй гишүүдийн бүлгийг өнөө хүртэл албан ёсны бүтэц болгоогүй явж ирсэн, жендэрийн тусгайлсан хороо, бүлэг огт байхгүй зэрэг нь албан ёсны зохицуулалт, бүтэц механизмаар жендэрийн асуудлыг дэмжих хандлага тааруу, жендэрийн хэвшмэл үзэл амь бөхтэй хэвээр байгаагийн нотолгоо юм.

УИХ төрийн эрх барих дээд байгууллагын хувьд ажлын ачаалал ихтэйн зэрэгцээ ажлын орчин жендэрийн мэдрэмжтэй байх асуудал орхигдсон. Жендэрийн асуудлаар гомдол мэдээлэл гаргах, ялангуяа ажлын байранд бэлгийн дарамт, хүчирхийлэлд өртөхөөс сэргийлэх механизм байхгүй. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилтанд ээлгүй, ажил-ар гэрийн амьдралын тэнцвэрийг хадгалах хөдөлмөрийн дүрэм журам тодорхой биш, цахим болон зайнаас ажиллах боломжууд нэвтрээгүй, жендэрт ээлтэй орчин бүрдүүлэх талаар авсан арга хэмжээ бараг байхгүй нь ажилтандаа болон гэр бүлд нь ээлгүй байгааг харуулж байна.

УИХ, түүний тамгын газрын түвшинд эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхсан үг хэллэг хэрэглэх, ажлын байрны бэлгийн болон бусад дарамт үзүүлэх асуудлаар тодорхой судалгаа хийгээгүй, энэ талаар мэдээлэл байхгүй байна. Эдгээр асуудлаар УИХ-ын хууль тогтоомж, УИХ-ын гишүүний ёс зүйн дүрэм зэрэгт тодорхой зохицуулалт тусгаагүй байна.

УИХ-аас гаргаж буй хэвлэл мэдээллийн жендэрийн мэдрэмжийн талаар аудит дүн шинжилгээ хийсэн зүйл байхгүй. Хэвлэл мэдээллийн орчинд, ялангуяа цахим орчинд УИХ-ын эмэгтэй гишүүд, удирдах албаны эмэгтэйчүүдийг ялгаварлах, доромжлох, жендэрийн мэдрэмжгүй хэвшмэл үг хэллэг хэрэглэх байдал түгээмэл байдаг. Энэ талаарх цахим орчинд гарсан сөрөг мэдээлэл 2023 оны эхний 5 сард өмнөх оноос 2.3 дахин, 2021 оноос 4.1 дахин өсчээ. Эдгээрийн дийлэнх нь тухайн хувь

хүний шинж чанарыг дурдаж доромжилсон, нэр хоч өгсөн, ёжилсон өнгө аястай байна. Эх сурвалжийн хувьд 59% нь хэвлэл мэдээллийн суваг, 27% нь хувь хүн бөгөөд тэдгээрийн 86% нь нэр хаягаа ил тодоор мэдээлж байгаа нь энэ үйлдлээ хэвийн зүйл мэтээр үзэх, жендэрийн хэвшмэл үзлийн талаар ойлголтгүйг харуулж байна.

Парламент дахь жендэрийн мэдрэмжтэй бодлого, соёл орчинг сайжруулахын тулд хийж хэрэгжүүлэх зүйлс

1. УИХ-ын гишүүд, УИХ-аас байгуулдаг байгууллагын болон Тамгын газрын удирдлага, албан хаагчдын жендэрийн мэдлэг ойлголт хандлагыг сайжруулж, жендэр бол зөвхөн эмэгтэйчүүдийн асуудал гэх буюу шийдвэр гаргах дээд түвшинд эмэгтэйчүүд тохирохгүй гэж үзэх жендэрийн хэвшмэл үзлээс ангижрахад чиглэсэн бодлого, үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх.
2. УИХ-ын гишүүдийн жендэрийн хүсэл зориг, манлайллыг өндөржүүлэх, жендэрийн үзэл баримтлал, арга барилд суралцуулах сургалт чадавхжуулалтын хөтөлбөр тусгайлан хэрэгжүүлэх.
3. УИХ-ын түвшинд хүйсээр ангилсан мэдээллийг нарийвчлан гаргаж, жендэрийн дүн шинжилгээ хийж, түүнд түшиглэсэн бодлого, үйл ажиллагааг УИХ-ын багц хууль, дүрэм журамд тусгах.
4. ПССХ жендэрийн статистикт хүчин зүйлийн шинжилгээ хийж, шалтгаан, үр дагаврыг тодорхойлсон чанарын үндэслэлүүд гаргаж, нотолгоонд суурилсан мэдээллээр УИХ-ын институцийг хангах.
5. Жендэрийн статистик мэдээллийг учир шалтгаан, чанарын үнэлгээ дүгнэлтийн хамт энгийн ойлгомжтой байдлаар иргэд олон нийтэд хүргэдэг тогтолцоог бий болгох.
6. Бага насны хүүхэдтэй, хөгжлийн бэрхшээлтэй зэрэг УИХ-ын гишүүний УИХ-ын үйл ажиллагаанд оролцох шаардагдах зохицуулалтыг хуульд тусгах.
7. Ажилтны хөдөлмөрийг үнэлэх, цалин хөлс урамшууллыг олгох ажлын байрны онцлогт тохирсон зохицуулалт хийж, нормчлогдоогүй ажлын цагтай гэдгээр зөвхөн биечилсэн бүртгэлийн системд үндэслэдэг байдлыг ажлын бүтээмж, ур чадвар, ажлын ачаалал, үр дүн, гүйцэтгэлд тулгуурлах байдлаар уян хатан зохицуулах, аль болох илүү цагаар ажиллуулахгүй байх, ажилласан бол нэмэгдэл цалин хөлсийг бүрэн олгодог журамд шилжих.
8. Ажилтны амьдралын нөхцлийг судлан, бага насны, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эх, эцэг зэрэг онцлог хэрэгцээтэй ажилтанд зайнаас, уян хатан цагаар ажиллах, ар гэр, үр хүүхэддээ анхаарах боломж олгох зэргээр ажлын байрыг ажилтанд болон гэр бүлд нь ээлтэй болгох.
9. Хөгжлийн бэрхшээлтэй ажилтан, гишүүн ажиллах орчин нөхцлийг бүрдүүлэх, уян хатан ажиллах боломжоор хангах.
10. УИХ-ын гишүүн нь бодит бус хугацаатай яаралтай үүрэг даалгавар өгөх зэргээр Тамгын газрын болон бусад байгууллагын ажилтан илүү цагаар, амралтын өдрүүдэд ажиллахад хүргэдэг байдлыг анхаарч, энэ асуудлыг УИХ-ын гишүүний ёс зүйн дүрэмд тусгах.
11. УИХ-ын өөрийн зохицуулалтын хууль, ёс зүйн дүрэм, хөдөлмөрийн дотоод журам, бусад журамд жендэрийн үнэлгээ хийж шинэчлэх, ажлын байрны бэлгийн болон бусад дарамт, ялгаварлан гадуурхалтаас сэргийлэх, гомдол хүлээн авах, шийдвэрлэх зохицуулалт бий болгох.
12. УИХ-аас түгээж буй хэвлэл мэдээлэлд жендэрийн үнэлгээ хийж, цаашид хэвлэл мэдээллийн жендэрийн мэдрэмжтэй байдлын шалгуур үзүүлэлтийг мөрдөж ажиллах, сонгогчдын жендэрийн боловсролд ахиц дэвшил гаргах.

13. Хувцас солих болон хүүхэд хөхүүлэх өрөөтэй болох, УИХ-ын гишүүн, ажилтны тоо нэмэгдэхтэй холбоотойгоор ариун цэврийн өрөө, бусад үйлчилгээг хэрэгцээнд нийцүүлэн шинэчлэх.
14. УИХ, түүний Тамгын газар өөрийн төсвийг жендэрийн үнэлгээнд тулгуурлан, ил тод, ажилтны оролцоотойгоор жендэрийн мэдрэмжтэй төлөвлөх арга барилд шилжих.
15. Жендэрийн мэдрэмжтэй ажлын байрны бодлогоор ажилтны нийгмийн баталгааг хангахад дэвшил гаргах.
16. 2024 оны парламентаас эхлэн мөрдөх бодлого, хууль, журамд жендэрийн энэхүү үнэлгээнээс гарсан зөвлөмжийг бүрэн тусгаж батлах.

ТАЙЛАН, САНАЛ, ЗӨВЛӨМЖТЭЙ ТАНИЛЦСАН:

УИХ-ЫН ГИШҮҮН,
ХҮНИЙ ЭРХИЙН ДЭД ХОРООНЫ ДАРГА

Ц.МӨНХЦЭЦЭГ

**“ХҮНИЙ ЭРХ, ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ ПАРЛАМЕНТ”
ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР**

Оролцогчид: Нийт 87 хүн

1. Монгол Улсын Их Хурлын гишүүд;
2. Олон Улсын Парламентын Холбооны төлөөлөл;
3. Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын ажилтнууд;
4. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, Жендэрийн Үндэсний хороо;
5. Төрийн байгууллагууд, иргэний нийгмийн төлөөлөл.

Өдөр I. 2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр, Лхагва гараг

Цаг	Үйл ажиллагаа	Илтгэгч, чиглүүлэгч
НЭГДСЭН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ: “Их эзэн Чингис хаан” танхим		
Хэлэлцүүлгийн даргалагч: Ц.Мөнхцэцэг Улсын Их Хурлын гишүүн, Хүний эрхийн дэд хорооны дарга, Улс төр судлалын доктор (Ph.D)		
08.30-09.00	Бүртгэл, өглөөний цай	
09.00-09.20	Нээлт Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын дарга Мартин Чунгонг Олон Улсын Парламентын Холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга Стефани Бурри Швейцарын хөгжлийн агентлагийн дарга	
Танилцуулах хэсэг I. Хүний эрх, жендэрийн эрх тэгш байдлыг хангах парламентын үүрэг, хариуцлага		
09.20-09.50	Хүний эрх, жендэр ба Монгол Улсын Их Хурал	Д.Цогтбаатар Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүйн байнгын хорооны дарга
09.50-10.20	Парламентын институц дэх хүний эрх, жендэрийн бодлого, хэрэгжилт	М.Үнэнбат Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга
10.20-10.45	Танилцуулгуудын дараа хэлэлцүүлэг явуулна.	
10.45-11.00	Цайны завсарлага	
Танилцуулах хэсэг II. Монгол Улс дахь бодлого, эрх зүйн орчин		
11.00-11.20	Хүний эрхийн үндэсний байгууллага болон парламентын хамтын ажиллагаа: Хүний эрх, жендэрийн эрх тэгш байдлын асуудлаарх олон улсын гэрээг хэрэгжүүлэх нь	Ж.Хунан Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга
11.20-12.20	Монгол Улс дахь хүний эрхийн бодлого, эрх зүйн орчин	Д.Гэрэл Хүний эрхийн үндэсний зөвлөх, НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хорооны гишүүн Б.Болорсайхан Хүний эрхийн үндэсний зөвлөх, хүний эрх судлаач
	Монгол Улс дахь жендэрийн эрх тэгш байдлын бодлого, эрх зүйн орчин	Б.Долгор Жендэрийн үндэсний зөвлөх, Жендэрийн үндэсний шинжээч

		М.Батбаатар Жендэрийн үндэсний зөвлөх, МУИС-ийн Социологийн тэнхмийн эрхлэгч, Социологийн ухааны доктор (Ph.D)
12.20-13.00	Танилцуулгуудын дараа хэлэлцүүлэг явуулна.	
13.00-14.00	Үдийн завсарлага	
Танилцуулах хэсэг III. Хүний эрх, жендэрийн мэдрэмжтэй парламентыг тодорхойлох нь		
14.00-15.00	<p>Парламент ба хүний эрх; Парламент ба жендэр – Жендэрийн мэдрэмжтэй парламентын талаарх ОУПХ-ны 2012 оны үйл ажиллагааны төлөвлөгөө ба 2022 оны Кигалийн тунхаглал Хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах болон жендэрийн мэдрэмжтэй хууль тогтоомж, бодлогын орчныг бэхжүүлэх парламентын үүргийг тодорхойлох нь</p> <p>Танилцуулгын дараа сэдвийн дагуу хэлэлцүүлэг явуулна.</p>	<p>Мэг Манн ОУПХ - Олон улсын зөвлөх</p> <p>Мариана Дуарте ОУПХ – Жендэрийн хамтын ажиллагааны хөтөлбөрийн мэргэжилтэн</p>
Танилцуулах хэсэг IV. Хүний эрх, жендэрийн өөрийн үнэлгээнд бэлтгэх нь		
15.00-16.00	<p>ОУПХ-ны боловсруулсан өөрийн үнэлгээний арга хэрэгслийг танилцуулах нь</p> <p>Хүний эрхийн болон жендэрийн асуудлаар хийх өөрийн үнэлгээний зорилго, хүрэх үр дүн, арга хэлбэр.</p> <p>Танилцуулгын дараа сэдвийн дагуу хэлэлцүүлэг явуулна.</p>	<p>Мэг Манн ОУПХ - Олон улсын зөвлөх</p> <p>Ботанья Ламхарзи ОУПХ – Хүний эрхийн хөтөлбөрийн мэргэжилтэн</p>
16.00-16.15	Нэгдсэн хэлэлцүүлгийн товч дүгнэлт	Ц.Мөнхцэцэг Улсын Их Хурлын гишүүн, Хүний эрхийн дэд хорооны дарга, Улс төр судлалын доктор (Ph.D)
16.15-16.30	Цайны завсарлага	
САЛБАР ХЭЛЭЛЦҮҮЛЭГ		
Оролцогчид 2 хэсэгт хуваагдан “Их эзэн Чингис хаан”, “Жанжин Д.Сүхбаатар” танхимуудад өөрийн үнэлгээнд оролцоно.		
Хэлэлцүүлгийн чиглүүлэгчид: Олон улсын болон үндэсний зөвлөхүүд		
Өөрийн үнэлгээний I хэсэг		
16.30-18.00	<p>Хүний эрхийн үнэлгээ: Хүний эрхийн мэдрэмжтэй хууль тогтоох үйл ажиллагаа</p> <p>Танилцуулгын дараа сэдвийн дагуу хэлэлцүүлэг явуулна.</p>	<p>Товч танилцуулга: Б.Жаргалмаа УИХ-ын гишүүн</p> <p>-УИХ-ын гишүүд, Тамгын газрын ажилтнууд -ОУПХ, Олон улсын зөвлөх -ОУПХ, Хүний эрхийн хөтөлбөр -Хүний эрхийн үндэсний зөвлөх -Холбогдох төрийн байгууллагууд, иргэний нийгмийн төлөөлөл</p>
	<p>Жендэрийн үнэлгээ: Парламент дахь эмэгтэйчүүдийн оролцоо (тоо, албан тушаал)</p>	<p>Товч танилцуулга: Д.Сарангэрэл УИХ-ын гишүүн</p> <p>-УИХ-ын гишүүд, Тамгын газрын ажилтнууд</p>

	Танилцуулгын дараа сэдвийн дагуу хэлэлцүүлэг явуулна.	-ОУПХ, Жендэрийн хөтөлбөр -Жендэрийн үндэсний зөвлөх -Холбогдох төрийн байгууллагууд, иргэний нийгмийн төлөөлөл
--	---	---

Өдөр II. 2023 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр, Пүрэв гараг

Цаг	Үйл ажиллагаа	Илтгэгч, чиглүүлэгч
САЛБАР ХЭЛЭЛЦҮҮЛЭГ		
Оролцогчид 2 хэсэгт хуваагдан “Их эзэн Чингис хаан”, “Жанжин Д.Сүхбаатар” танхимуудад өөрийн үнэлгээнд оролцоно.		
Хэлэлцүүлгийн чиглүүлэгчид: Олон улсын болон үндэсний зөвлөхүүд		
08.45-09.00	Өмнөх өдрийн үйл ажиллагааг сэргээн санах	
Өөрийн үнэлгээний II хэсэг		
09.00-10.30	Хүний эрхийн үнэлгээ: Парламентын хяналтыг бэхжүүлэх нь Танилцуулгын дараа сэдвийн дагуу хэлэлцүүлэг явуулна.	Товч танилцуулга: Ц.Сандаг-Очир УИХ-ын гишүүн -УИХ-ын гишүүд, Тамгын газрын ажилтнууд -ОУПХ, Олон улсын зөвлөх -ОУПХ, Хүний эрхийн хөтөлбөр -Хүний эрхийн үндэсний зөвлөх -Холбогдох төрийн байгууллагууд, иргэний нийгмийн төлөөлөл
	Жендэрийн үнэлгээ: Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хууль, эрх зүйн бодлого, тогтолцоо Танилцуулгын дараа сэдвийн дагуу хэлэлцүүлэг явуулна.	Товч танилцуулга: Ц.Мөнхцэцэг УИХ-ын гишүүн, Хүний эрхийн дэд хорооны дарга, Улс төр судлалын доктор (Ph.D) -УИХ-ын гишүүд, Тамгын газрын ажилтнууд -ОУПХ, Жендэрийн хөтөлбөр -Жендэрийн үндэсний зөвлөх -Холбогдох төрийн байгууллагууд, иргэний нийгмийн төлөөлөл
10.30-10.45	Цайны завсарлага	
НЭГДСЭН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ: “Их эзэн Чингис хаан” танхим		
Хэлэлцүүлгийн даргалагч: Ц.Мөнхцэцэг Улсын Их Хурлын гишүүн, Хүний эрхийн дэд хорооны дарга, Улс төр судлалын доктор (Ph.D)		
10.45-11.30	Нэгдсэн хэлэлцүүлэгт өөрийн үнэлгээний I-II дахь хэсгийн үр дүнгийн талаар УИХ-ын гишүүд/Үндэсний зөвлөхүүд тус бүр 10 минутанд багтаан танилцуулах	
САЛБАР ХЭЛЭЛЦҮҮЛЭГ		
Оролцогчид 2 хэсэгт хуваагдан “Их эзэн Чингис хаан”, “Жанжин Д.Сүхбаатар” танхимуудад өөрийн үнэлгээнд оролцоно.		
Хэлэлцүүлгийн чиглүүлэгчид: Олон улсын болон үндэсний зөвлөхүүд		
Өөрийн үнэлгээний III хэсэг		
11.30-13.00	Хүний эрхийн үнэлгээ: НҮБ-ын хүний эрхийн тайлагнах механизмд Парламентын оролцоог нэмэгдүүлэх нь Танилцуулгын дараа сэдвийн дагуу хэлэлцүүлэг явуулна.	Товч танилцуулга: Ц.Мөнх-Оргил УИХ-ын гишүүн -УИХ-ын гишүүд, Тамгын газрын ажилтнууд -ОУПХ, Хүний эрхийн хөтөлбөр -Хүний эрхийн үндэсний зөвлөх -Холбогдох төрийн байгууллагууд, иргэний нийгмийн төлөөлөл
	Жендэрийн үнэлгээ: Парламентад жендэрийн үзэл баримтлал нэвтрүүлэх нь	Товч танилцуулга: М.Оюунчимэг УИХ-ын гишүүн

	Танилцуулгын дараа сэдвийн дагуу хэлэлцүүлэг явуулна.	-УИХ-ын гишүүд, Тамгын газрын ажилтнууд -ОУПХ, Олон улсын зөвлөх -ОУПХ, Жендэрийн хөтөлбөр -Жендэрийн үндэсний зөвлөх -Холбогдох төрийн байгууллагууд, иргэний нийгмийн төлөөлөл
13.00-14.00	Үдийн завсарлага	
Өөрийн үнэлгээний IV хэсэг		
14.00-15.30	Хүний эрхийн үнэлгээ: Олон нийт ба хүний эрхийн бусад байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх нь Танилцуулгын дараа сэдвийн дагуу хэлэлцүүлэг явуулна.	Товч танилцуулга: О.Цогтгэрэл УИХ-ын гишүүн, УИХ дахь АН-ын бүлгийн дарга -УИХ-ын гишүүд, Тамгын газрын ажилтнууд -ОУПХ, Хүний эрхийн хөтөлбөр -Хүний эрхийн үндэсний зөвлөх -Холбогдох төрийн байгууллагууд, иргэний нийгмийн төлөөлөл
	Жендэрийн үнэлгээ: Парламент дахь байгууллагын соёл, орчин, бодлого Танилцуулгын дараа сэдвийн дагуу хэлэлцүүлэг явуулна.	Товч танилцуулга: Ж.Бат-Эрдэнэ УИХ-ын гишүүн -УИХ-ын гишүүд, Тамгын газрын ажилтнууд -ОУПХ, Олон улсын зөвлөх -ОУПХ, Жендэрийн хөтөлбөр -Жендэрийн үндэсний зөвлөх -Холбогдох төрийн байгууллагууд, иргэний нийгмийн төлөөлөл
15.30-15.45	Цайны завсарлага	
НЭГДСЭН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ: “Их эзэн Чингис хаан” танхим		
Хэлэлцүүлгийн даргалагч: Ц.Мөнхцэцэг Улсын Их Хурлын гишүүн, Хүний эрхийн дэд хорооны дарга, Улс төр судлалын доктор (Ph.D)		
15.45-16.30	Нэгдсэн хэлэлцүүлэгт өөрийн үнэлгээний III-IV дэх хэсгийн үр дүнгийн талаар УИХ-ын гишүүд/Үндэсний зөвлөхүүд тус бүр 10 минутанд багтаан танилцуулах	
16.30-17.45	Дүгнэлт, зөвлөмжийн хэсэг Хүний эрхийн үндэсний зөвлөхийн дүгнэлт, зөвлөмж Жендэрийн үндэсний зөвлөхийн дүгнэлт, зөвлөмж ОУПХ шинжээчийн дүгнэлт, зөвлөмж	
17.45-18.00	Хаалт Ц.Мөнхцэцэг Улсын Их Хурлын гишүүн, Хүний эрхийн дэд хорооны дарга, Улс төр судлалын доктор (Ph.D)	

**“ХҮНИЙ ЭРХ, ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ ПАРЛАМЕНТ”
ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ САЛБАР ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ЯВУУЛАХ ДАРААЛАЛ**

Өөрийн үнэлгээнд 8 асуулт (хүний эрх-4, жендэр-4)-ын хүрээнд 8 салбар хэлэлцүүлэг явуулах бөгөөд нэг салбар хэлэлцүүлэг 1 цаг 30 минут үргэлжилнэ. Салбар хэлэлцүүлгийн чиглүүлэгч нь Олон улсын болон Үндэсний зөвлөхүүд байна.

Салбар хэлэлцүүлэг тус бүрт оролцох оролцогчдын тоо 30 (нийт 60) байна. Нэг удаагийн салбар хэлэлцүүлэг доорх дарааллаар явагдана.

	Хугацаа	Үйл ажиллагаа	Дэлгэрэнгүй дараалал
1	10'	Тухайн асуултын хүрээнд олон улсын болон Монгол Улсын нөхцөл байдлын талаар товч танилцуулах	<ul style="list-style-type: none"> - Чиглүүлэгч ямар сэдвээр салбар хэлэлцүүлгийг явуулах талаар товч тайлбарлаж, сэдвийн хүрээнд танилцуулга хийх УИХ-ын гишүүнийг урина. - УИХ-ын гишүүн, эсхүл УИХТГ-ын удирдах албан тушаалтан тухайн асуултын хүрээнд 10 минутанд багтаан ПССХ-ээс боловсруулсан нөхцөл байдлын суурь судалгаа (баримт бичиг, өгөгдлийн тойм үнэлгээ)-ны холбогдох хэсгийг ашиглан товч танилцуулга хийнэ. - УИХ-ын гишүүнийг танилцуулга хийсний дараа хэлэлцүүлгийг сонгон авсан 4 асуултын хүрээнд эхлүүлнэ.
2	60'	Үндсэн хэлэлцүүлэг	<ul style="list-style-type: none"> - Нэг асуултын хүрээнд асуулт асуух, санал хэлэх, хариулах хугацаа дунджаар 2 минутаас хэтрэхгүй байхаар чиглүүлнэ. (Тоолуур ажиллуулна.) - Оролцогчдын зүгээс асуулттай холбоотой үг хэлэх хүн байгаа эсэхийг асууж, байгаа тохиолдолд саналыг 2 минутанд багтаан сонсоно. - УИХТГ, ХЭҮК, ЖҮХ, СЕХ, ТАЗ, УИХ-ын ахмад төлөөлөл, иргэний нийгмийн төлөөлөөс чиглүүлэгч шаардлагатай асуудлаар асуулт асууна. (Жич: УИХТГ-ын холбогдох ажилтанд хуваарилсан асуултын хүрээнд чиглүүлэгч УИХТГ-ын ажилтнаас асуултаа асууна.) - Оролцогчдын зүгээс асуулт асуух боломжийг мөн олгоно. (Үүний дараа 2-4 дэх асуултыг энэ дарааллаар дахин явуулна.)
3	15'	Санал, зөвлөмж хэлэх	<ul style="list-style-type: none"> - Тухайн салбар хэлэлцүүлгийн үеэр яригдсан асуудлыг хэрхэн шийдвэрлэх арга замуудын талаар хэлэлцүүлэгт оролцогчдын ярилсан зүйлс дээр тулгуурлан чиглүүлэгч, санал, зөвлөмжөө хэлнэ. - Олон улсын зөвлөхийг санал, зөвлөмжөө хэлэхийг хүсч, санал, зөвлөмжийг сонсоно.
4	5'	Тухайн асуудлаар товч дүгнэлт хийх	<ul style="list-style-type: none"> - Хэлэлцүүлгийн чиглүүлэгч салбар хэлэлцүүлгийн нийт үр дүнгийн талаар товч дүгнэлт хийнэ. - Салбар хэлэлцүүлгийн товч үр дүнг нэгдсэн хэлэлцүүлэгт танилцуулах албан тушаалтан (УИХ-ын гишүүн, эсхүл олон улсын болон үндэсний зөвлөх)-ийг томилно.